



МАНАЙ ХОРООНД *Шавтай Мори*

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар хотын иргэн бүрийн мэдвэл зохих эрх үүрэг тэдгээрийг зохицуулсан шийдвэр болон зөвлөмжүүдийг уг гарын авлагад тусгасан болно.



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарын хөгжлийн агентлаг

COWI

EBP

ICON
ИКОН ХХК

МАНАЙ ХОРООНД *Шавтай Мори*

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар хот
2021 он

Хэрэгжүүлэгч:



COWI

EBP



Энэхүү гарын авлагыг Улаанбаатар хотын иргэн бүрийн мэдвэл зохих эрх үүрэг, тэдгээрийг зохицуулсан шийдвэр болон зөвлөмжүүдийг тусган Швейцарын Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр хэрэгжиж буй Улаанбаатар хотын Ахуйн Хог Хаягдлын Цуглуулалт, Тээвэрлэлтийн Менежмент Төслийн (УБАХХЦТМ) хүрээнд Чингэлтэй болон Сонгинохайрхан дүүргийн иргэдэд зориулан хэвлэв.





Өрхийн бүртгэлийн мэдээлэл

Өрхийн тэргүүний

Овог _____

Нэр _____

Ам бүлийн тоо _____

Хороо _____

Хороолол _____

Хотхон _____

Тоот _____

Гарын үсэг _____

МАНАЙ ХОРООНД ТАВТАЙ МОРИЛ

Сайн байна уу танд энэ өдрийн мэнд хүргэе. Манай хороонд ажиллаж, амьдрах гэж байгаа бүх хүмүүст бидний үүд хаалга үргэлж нээлттэй байдаг. Бид иргэдийнхээ ажиллаж, амьдрахад ээлтэй, эрүүл, аюулгүй, таатай орчинг бүрдүүлэхэд бүх боломж бололцоогоо дайчлан ажиллаж, ямагт нийтийн эрх ашгийн төлөө та бүгдтэй хамтран ажиллах болно.

Та энэхүү гарын авлагад тусгагдсан үүрэг амлалтуудыг биелүүлж бидэнтэй хамтран ажиллана гэдэгт итгэж байна.

Бид бүгдээрээ иргэн хүнийхээ үүрэг хариуцлагаа ухамсарлаж Улаанбаатар хотынхоо бодлого, журмыг чандлан мөрдөж, бусдыг хүндлэн бие биедээ үлгэр дууриалал үзүүлж хамтдаа хөгжих цаг үе ирээд байна. Энэхүү гарын авлагад өдөр тутамд тохиолддог хүндрэл бэрхшээлтэй асуудлуудыг хэрхэн шийдэх зөвлөгөө мэдээлэл, хэн ямар асуудлыг хариуцах, ямар үүрэг амлалт хүлээх талаар тодорхой тусган оруулсан байгаа.

ХОТЫН ИРЭЭДҮЙН ИХ ХӨГЖИЛ ӨНӨӨДРИЙН НЭГ АЛХМААС ЭХЭЛНЭ.

ТАНЫ ГЭР БҮЛ, ХАМТ ОЛОНД АЗ ЖАРГАЛ ЭРҮҮЛ ЭНХ, САЙН САЙХАН БҮХНИЙГ ХҮСЭН ЕРӨӨЕ

Агуулга

I. Хотын соёл

- 1.1 Хотын соёл гэж юу вэ?
- 1.2 Нийгэмд эерэг өөрчлөлт оруулахад бид хэрхэн хувь нэмрээ оруулах вэ?

II. Улаанбаатар хотын түүхэн товчоон

- 2.1 Түүхэн замнал
- 2.2 Сонгинохайрхан дүүрэг
- 2.3 Чингэлтэй дүүрэг

III. Иргэн таны гэр бүлд хэрэгтэй мэдээлэл, зөвлөмжүүд

A. Хашаандаа сайхан амьдарцгаая.

- * Хашаагаа хэрхэн зөв төлөвлөх вэ?
- * Хашаандаа мод тарьсан уу, хэрхэн ногооруулах вэ?

B. Хог хаягдал-Хогоо эх үүсвэр дээр нь ангилж хэвшицгээе.

- * Хог хаягдал гэж юу вэ? /Энгийн болон ахуйгаас гарах аюултай хог хаягдал/
- * Хогоо хэрхэн ангилж хаях вэ?
- * Хог хаягдлаа ямар хуваарийн дагуу ачуулах вэ?
- * Хог хаягдлын үйлчилгээний хураамжаа хэрхэн төлөх вэ?
- * Хог хаягдлын асуудлаар та хэнд хандах вэ?
- * Хүнсний болон бусад органик хаягдлаар хэрхэн бордоо хийх вэ?

C. Ус, дулаан, цахилгаан-Ус, эрчим хүчээ хэмнэцгээе.

- * Бид ямар тарифаар ус, дулаан, цахилгааны төлбөрөө төлдөг вэ?
- * Ус, дулаан, цахилгаантай холбоотой гэмтэл гарвал хашаа хандах вэ?
- * Энэ үед та хамгийн түрүүнд ямар арга хэмжээ авах вэ?
- * Дундын эзэмшлийн дулаан, цахилгаан гэж юуг хэлэх вэ?

D. Хөрс-Хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлье.

- * Та нүхэн жорлон ашигласаар л байна уу?
- * Танд санал болгох ахуйн шаардлага хангасан жорлонгийн шийдлүүд
- * Жорлонгоо хэрхэн үнэргүй, цэвэр байлгах вэ?
- * Хашаан доторх хөрсөө хэрхэн эрүүлжүүлж, ногооруулах вэ?

E. СӨХ гэж юу вэ?

- * СӨХ ямар үүрэгтэй вэ?
- * Та СӨХ-тэйгөө хэрхэн хамтарч ажиллах вэ?
- * Нийтийн орон сууцанд бусадтай хөрш болж амьдрахад таны оролцоо юу вэ?

F. Агаар-Агаарын бохирдлыг хамтдаа бууруулъя.

- * Сайжруулсан шахмал түлш гэж юу вэ, түүнийг хэрхэн зөв хэрэглэх вэ?
- * Ахуйн зуухны ямар ямар төрлүүд байдаг вэ?
- * Хэрхэн зуухаа сонгох вэ?
- * Цахилгаан халаагуурт хэрхэн шилжих вэ?
- * Цахилгаан халаагуурын ямар шийдлүүд байдаг вэ?
- * Түүнийг хэрхэн сонгох вэ?
- * Гэр, байшингаа хэрхэн дулаалах вэ?

G. Хотын зуслан ногоон бүсээ хайрлаж хамгаалцгаая.

- * Хотын аль хэсэг зуслан ногоон бүсэд хамаардаг вэ?
- * Байгаль хамгаалагч гэж хэн бэ?
- * Зуслангийн товчооны талаар та мэдэх үү?

H. Онцгой байдал-Болзошгүй аюулд бэлэн байцгаая.

Гал түймэр, газар хөдлөлт, үерийн үед гэр бүлээ өөрийгөө хэрхэн хамгаалах вэ? хамгийн түрүүнд та хэнд хандах вэ?

I. Эрүүл мэнд-Өрхийн гишүүн бүрээ эрүүл байлгацгаая.

- * Өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ гэж юу вэ?
- * Өрхийн эмнэлэгтэйгээ хэрхэн холбогдох вэ?
- * Ахуйн осол гэмтлийн үед гэр бүлдээ болон өөртөө анхны тусламжийг хэрхэн үзүүлэх вэ?
- * Анхны тусламж шаардлагатай үед хамгийн түрүүнд хэнд хандах вэ?
- * Эмийн зохистой хэрэглээ гэж юу вэ?
- * Ахуйгаас гарах эмнэлгийн хог хаягдлын хор нөлөө

J. Гэмт хэрэг зөрчил-Гэмт хэрэг зөрчлөөс хамтдаа сэргийлье.

- * Гэр бүлийн хүчирхийлэл гэж юу вэ?
- * Хөршүүдийнхээ амар тайван байдлыг хэрхэн хангах вэ?
- * Таны хөршид гэмт хэрэг, хүчирхийлэл үйлдэгдсэнийг та мэдвэл хэнд хандах вэ?
- * Танай хөршийнд болон танайд хулгай орсон тохиолдолд та хэрхэн хаашаа хамгийн түрүүнд хандах вэ?

K. Оршуулгын үйлчилгээ.

- * Өрхийн гишүүн нас барсан тохиолдолд та хамгийн түрүүнд хаашаа хандах вэ?
- * Оршуулгын үйлчилгээ үзүүлдэг ямар аж ахуйн нэгжүүд байдаг вэ?
- * Зөвшөөрөлтэй ямар оршуулгын газрууд байдаг вэ?
- * Оршуулгын зан үйлтэй холбоотой түгээмэл асуултын хариулт.

IV. Цахимаар авах боломжтой төрийн байгууллагуудын үйлчилгээ

V. Шаардлагатай утасны жагсаалт

Иргэний үүрэг амлалт

Эрхээ мэддэг иргэн
Үүргээ ухамсарласан байдаг

- 1 Манай гэр бүл орцондоо хогоо хаяхгүй, гадаа ил задгай үүсмэл хог үүсгэхгүй, хогоо хог ачих цэгт байршуулж, зааврын дагуу ангилан ялгалт хийж мөн бүх нийтийн их цэвэрлэгээнд оролцож хэвшинэ.
- 2 Манай гэр бүл хог хаягдлын хураамжаа тогтсон хугацаанд нь төлж байна.
- 3 Байрны засвараас гарсан барилгын хог болон овор ихтэй хогоо эрх бүхий мэргэжлийн байгууллагад нэмэлт үйлчилгээний хөлс төлж тээвэрлүүлнэ.
- 4 СӨХ-ын үйл ажиллагаанд хяналт тавих, дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.
- 5 Дүүрэг хорооноос зохион байгуулж буй сургалт, олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцоно.
- 6 Цас орсон даруйд хөршүүдээрээ хамтран халтиргаа гулгааг арилган иргэдийн бэртэх гэмтэх эрсдэлийг бууруулна.
- 7 Шүлс, нус, цэрээ орц, байрныхаа нийтийн гадна талбай, хүүхдийн тоглоомын талбайн ойр орчимд хаяхгүй байж, ил задгай бие засахгүй байна.
- 8 Ханиад томуу туссан болон аливаа өвчний дэгдэлтийн үед амны хаалтыг өрхийн гишүүн бүрээр хэрэглэж, өрхийн гишүүдийнхээ болон хөршүүдийнхээ эрүүл мэндийг хамгаална.
- 9 Тогтоосон цэгт тамхи татаж, бүрэн унтраан гал гаргах эрсдэлээс сэргийлнэ.
- 10 Хөршүүдийнхээ амар тайван байдлыг алдагдуулахгүй байж архидан согтуурч чанга дуу чимээ гаргахгүй байна.
- 11 Гэрийн тэжээвэр нохойгоо тогтоосон цэгт салхилуулж, бохирдсон хэсгийг тухай бүрд нь цэвэрлэж байна.
- 12 Хөршүүд хүчирхийлэлд автах аюулд өртөж байгааг мэдвэл цаг алдалгүй цагдаагийн байгууллага болон бусад холбогдох байгууллагуудад мэдэгдэнэ.

Гэрийн хаяг: _____
 Овог нэр: _____
 Гарын үсэг: _____
 Он сар өдөр: _____

Хорооны үүрэг, амлалт

Хорооноос таны
ажил амьдрал эхэлдэг

- 1 Иргэн, ААНБ, СӨХ бүрийг бүртгэн авч, мэдээллийг хүртээмжтэй хүргэн хяналт тавина.
- 2 Хорооны нутаг дэвсгэрийг хог хаягдалгүй, халтиргаа гулгаагүй, эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлэхэд бүхий л боломж бололцоог дайчлан ажиллана.
- 3 Хог ачиж, цуглуулах, тээвэрлэх хуваарийн хэрэгжилтэд хяналт тавьж зөрчлийг шуурхай шийдвэрлүүлнэ.
- 4 Хорооны иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг дүүргээс зохион байгуулж буй сургалт, сурталчилгаанд хамруулна.
- 5 Айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлыг ангилан ялгуулж хэвшүүлнэ.
- 6 Иргэд, ААНБ, СӨХ-ыг бүх нийтийн их цэвэрлэгээнд жигд оролцуулан идэвхжүүлнэ.
- 7 Дээд байгууллагаас ирсэн захирамж, тушаал, шийдвэрийг иргэд, ААНБ, СӨХ-дод танилцуулах, хэрэгжилтийг хангуулна.
- 8 ААНБ-уудтай жил бүр тохижилт цэвэрлэгээний болон худалдаа үйлчилгээ эрхлэх гэрээг байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.
- 9 Гэрээгээр хүлээсэн үүргээ тогтмол сайн биелүүлдэг ААН, иргэний үйл ажиллагааг дэмжин, нийслэл дүүргийн шагналд тодорхойлох, санал өгөх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилна.
- 10 Хүн амын хүнсний хангамжийг сайжруулахад орон нутгийн нөөц бололцоог илрүүлж ашиглах ажлыг зохион байгуулах, энэ талаар иргэдээс гаргасан санаачилгыг дэмжинэ.
- 11 Хүн амын боловсролын төвшинг судлах, сургуулийн өмнөх насны хүүхдийг бүртгэж тухайн жилд нь сургуульд оруулах, сургууль завсардсан хүүхдийг сургалтад хамруулах арга хэмжээ авна.
- 12 Шаардлагатай иргэдийг асрамжийн болон халамжийн үйлчилгээнд хамруулах саналыг хууль тогтоомжийн дагуу дүүргийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлнэ.
- 13 Захиргааны журмын биелэлтэд хяналт тавьж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах, энэ ажилд иргэдийг татан оролцуулах, санал, санаачлагчийг нь дэмжин ажиллана.
- 14 Иргэдийн өргөдөл, санал, гомдлыг хүлээн авч хамрах хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх буюу холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжилна.

Дүүрэг: _____
 Засаг даргын овог нэр: _____
 Гарын үсэг: _____
 Он сар өдөр: _____

СӨХ-ын үүрэг, амлалт

66

Хөгжлийн эхлэл
Хамтрахад оршино.

- 1 Оршин суугчид болон ААНБ-ыг үнэн зөвөөр бүртгэж авсан байна.
- 2 Оршин суугчдад болон ААНБ-дад үйл ажиллагаагаа танилцуулсан байна.
- 3 Эзэмшлийн талбайн хил заагаас гадагш орчны 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газар, зам талбайн хог хаягдал хөл газрын ургамал, цас мөсийг өдөр бүр тогтмол цэвэрлэнэ.
- 4 Байрны гадна байршуулах хогийн савыг хаалга, дээвэртэй, агаар орох нөхцөлийг бүрдүүлсэн, шимэгч хорхой мэрэгч, шувуу, амьтан орох боломжгүй байлгана.
- 5 Хог ачих цэгийг тогтмол ариутгана.
- 6 Эрх бүхий мэргэжлийн байгууллагатай “Хог ачиж, тээвэрлүүлэх гэрээ” байгуулж хог тээвэрлэх хуваарийг оршин суугчдад танилцуулан хуваарь мөрдөлтөд хяналт тавьж ажиллана.
- 7 Оршин суугчдад болон ААНБ-ыг хогоо ангилж хэвшүүлэхэд тогтмол зөвлөгөө мэдээллийг өгч ажиллана.
- 8 Бүх нийтийн их цэвэрлэгээнд иргэд, ААНБ-ыг идэвхжүүлэн оролцуулах, хог хаягдлыг ил задгай овоолон орхихгүй байх шатааж агаар орчны бохирдлыг үүсгэхгүй байна.
- 9 Орон сууцны ойролцоо байрлах нийтийн эдэлбэр газар, гудамж талбайн хайс хашлага, архитектурын жижиг байгууламжийг угааж, цэвэрлэн будаж, өнгийг сэргээж байна.
- 10 Орон сууц, нийтийн байрны орц, шатны хонгил, цонх, хаалгыг угааж цэвэрлэдэг байна.
- 11 Хамаарал бүхий инженерийн шугам сүлжээний бүрэн бүтэн байдлыг хангана.
- 12 Оршин суугчдын эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэн камержуулалт болон бусад засвар үйлчилгээг тогтмол хийж байна.
- 13 Хороо, дүүрэг, цагдаа, онцгой байдал, орон сууцны контортой нягт хамтран ажиллана.
- 14 Цаг үеийн яаралтай авах арга хэмжээний үеэр оршин суугч бүрд хүрч ажиллах.
- 15 Хийсэн ажлуудаа өдөр тутамдаа онлайнаар оршин суугчиддаа танилцуулах, санхүү болон үйл ажиллагааны тайланг оршин суугчид болон удирдах зөвлөлд жилд 2-оос доошгүй удаа албан танилцуулга хийнэ.
- 16 Хогийн цэггүй ААНБ-уудын хогийг СӨХ-ны хог ачих цэгт төвлөрүүлэн гэрээ байгуулан ажиллах

Дүүрэг:

Хорооны дугаар:

СӨХ-ын нэр:

СӨХ-ын даргын гарын үсэг

Он сар өдөр



Хотын соёл

Хотын соёл гэж юу вэ?

Байгальд орших мянга мянган төрөл зүйл амьтдаас зөвхөн хүн л соёл хэмээх ухагдахууныг бий болгон оршдог.


Тэгэхээр ухамсарт хүн төрөлхтний зөв, эерэг үйлдэл, дадал зуршил, дэг журам, хууль, эрх зүйг дээдлэн хүндлэхийг соёл хэмээн ойлгож болно.

Хотын соёл гэж хотод амьдрах зөв хэвшил юм. Хотод олон хүмүүс ажиллаж амьдардаг учраас нэг хүний эрх ашиг болон сонирхол нь нийт олны эрх ашигт захирагдах учиртай.



Хотын соёл энгийн зүйлээс эхэлдэг

Бидний орчин бол бидний хандлагын толь



Зөвлөмж

Энгийн үгээр тайлбарлавал соёлтой хот байхад иргэдийн мэдлэг, хандлага зан үйлийг хуучин уламжлалт хэв маяг, хандлагаас салгаж өөрчлөх, Хот ямар дүрэм, журам, үйлчилгээний стандартыг мөрдөж байна тэрийг иргэдэд ойлгуулж дагаж мөрдүүлэх нь чухал юм. Хүн хүүхэд байхаас өсөж байгаа орчноосоо ээж ааваасаа, гэр бүлээсээ соёлын суурь хүмүүжил төлөвшилтийг олж авч байдаг. Тиймээс хотын соёлыг гэр бүлийн соёлоос эхэлж төлөвшүүлэх нь чухал юм.

Нийгэмд эерэг өөрчлөлт оруулахад та хэрхэн хувь нэмрээ оруулах вэ ?



Ишлэл - Өөрт чинь бүү тохиолдог гэсэн зүйлээ чи өөрөө бусдад бүү үйлд. Өөрт чинь тохиолдоосой гэсэн зүйлээ чи эхлээд өөрөө бусдад үйлд".

Ричард Шеридан

ТҮҮХЭН ЗАМНАЛ

Улаанбаатар хотын түүх бол монголчуудын эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл, тусгаар тогтносон орны улс төр, эдийн засаг, шашин, соёлын төвийн түүх, монголчуудын бэлгэдэл юм. Нийслэл хот маань 1778 онд Хан Богд уулын ар, Хатан Туулын хөвөө буюу Хүн чулууны хонхор, Алтан тэвшийн хөндий хэмээх энэ газарт төвхнөх хүртлээ 30 жилийн дотор 28 удаа нүүдэл суудал хийж байсан түүхтэй.

Анх 1639 онд одоогийн Өвөрхангай аймгийн Бүрд сумын нутаг Цагаан нуур буюу Ширээт нуур гэх газар шашны тэргүүнээр өндөр гэгээн Занабазарыг өргөмжлөхдөө түүнд зориулан орд өргөөг байгуулсан нь өнөөгийн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын үүсэл болсон гэж үздэг юм. Өргөө нь Монголын шарын шашин, Халх Монголын улс төрийн төв, гадаад, дотоодын худалдааны чухал зангилаа голомт байв. Энэ үеэс Өргөө нь жинхэнэ хот болон дэгжин хөгжих шинэ үедээ оржээ.

Өргөө нэртэй, анх ханаа дугуйлсан нийслэл хотын нэрийг Номын хүрээ хэмээн өөрчилж байв. Энэ үеийн онцлог нь Их Хүрээ суурьшиж хот болон хөгжиж ирсэн явдал гэж түүхчид үздэг. Их Хүрээ нь 1706-1911 он хүртэл одоогийн Улаанбаатар хотын төв Сэлбэ голын хөндийд төвлөжээ. 19-р зууны үед Их Хүрээ нь шашны төв төдийгүй худалдаа харилцааны зангилаа, жинхэнэ хот болсон юм. Энэ үед Их Хүрээний хүн ам 15-20 мянга байсан гэж үздэг. Их Хүрээ хотод Гандан, зүүн Хүрээ, Баруун дамнуурчин, Наймаа, консулын яам, Дамбадаржаа гэсэн газрууд хамрагдаж байв. Их Хүрээ нь 19-р зууны эцэс гэхэд Монгол орны шашин, улс төр, худалдаа, үндэсний болон нийгмийн зөрчил тэмцлийн гол төв байлаа.

Ардын хувьсгал ялсны дараа, 1924 оны 10-р сарын 29-нд улсын нийслэл гэдгийг давтан хуульчилж, хотын нэрийг Улаанбаатар болгон өөрчилсөн юм. 100 гаруйхан жилийн Төв Азийн нүүдэлчдийн эсгий хот байсан Улаанбаатар минь "Азийн цагаан дагина" хэмээн Азийн орнуудаар дуудуулах хүртлээ хөгжин дэвжихэд бидний өвөг дээдсийн оруулсан хувь нэмэр, гавьяа зүтгэл өгүүлшгүй их. 1954 онд анх удаа Улаанбаатар хотыг хөгжүүлэх 20 жилийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлж эхэлжээ. 1992 онд баталсан Монгол Улсын шинэ Үндсэн хуульд Монгол Улсын нийслэл нь Улаанбаатар хот мөн хэмээн зааж, нийслэл нь өөрийн туг, бэлгэ тэмдэгтэй болж байв. Өнөөдөр Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, 2030 он хүртэл хөгжүүлэх төлөвлөлтийг боловсруулаад байна. Өнөөгийн Улаанбаатар хот нь Монгол Улсын Нийслэл бөгөөд Баянзүрх, Баянгол Багануур, Багахангай, Налайх, Чингэлтэй, Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй, Хан-Уул гэсэн 9 дүүрэгт хуваагддаг ба далайн түвшнээс дээш 1351 м өндөрт оршиж нийт 4,704.4 м.кв талбайг хамарч байна.

Улаанбаатар хотын Түүхэн товчоон

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Сонгинохайрхан дүүрэг нь нийслэл хотын баруун талд орших Сонгино хайрхан уулын нэрээр нэрлэгдсэн юм. Энэхүү уулын оргил нь далайн түвшнээс 1663 метр өндөр.

Уг хайрхан нь арслан савдагтай байсан учир Арсланхайрхан хэмээн нэрлэдэг байсан байна. Чингис хаан нэгэнтээ 8 өрлөг, 13 баатрын хамт өнөөгийн Улаанбаатар хот орших газар буюу үзэсгэлэнт сайхан

Алтан тэвшийн хөндийд саатан тухалсан аж. Чингээд Арслан хайрханы бэлээр явж байтал арслан хүрхрэх мэт дуу гарч, хад асга нурав гэнэ. Харин нэг сонгино өнхрөн өнхөрсөөр хааны өлмийнд тулж тогтсон тул ихэд бэлэгшээн Сонгино уул хэмээн нэрлэсэн домогтой юм байна.

Сонгино хайрхан дүүрэг нь 1992 онд тухайн үеийн Октябрийн районыг хоёр хуваахад, Монгол УИХ-ын 1992 оны 18-р тогтоолын дагуу Сонгинохайрхан дүүргийн ИТХ 100 төлөөлөгчтэйгээр анхны хуралдаанаа хийж Сонгинохайрхан дүүргийг байгуулах тухай тогтоолыг 1992 оны 10 сарын 1-ний өдөр гаргаснаар тус дүүрэг албан ёсоор байгуулагдсан юм.

Сонгино хайрхан дүүрэг нь Хан-Уул, Баянгол дүүргүүдээр хил залгаа оршдог бөгөөд 120,6 га газар нутагтай, анхан шатны засаг захиргааны 43 хороо, 322000 гаруй хүн амтай, 84,236 өрхтэй ба Монгол улсын нийт хүн амын 11% нийслэлийн хүн амын 25% эзэлж байгаа нийслэлийн том дүүрэг юм. Нийт өрхийн 30 хувь нь орон сууцанд, 70 хувь гэр хороололд амьдардаг байна.

11%

МОНГОЛ УЛСЫН
НИЙТ ХҮН АМЫН

25%

НИЙСЛЭЛИЙН НИЙТ
ХҮН АМЫН

84.236

ӨРХТЭЙ

322.000

ХҮН АМТАЙ

120.6 ГА

ГАЗАР НУТАГТАЙ

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

320.000

ХҮН АМТАЙ

89.3

МЯНГАН ГА
ГАЗАР НУТАГТАЙ

231

ТӨСВИЙН
БАЙГУУЛЛАГА

Их хүрээг өнө суурьшуулах газар шинжин явсан мэргэд Ар Халхын нутгийн баруун хэсэгт овоо тахилгатай, үзэсгэлэн төгс Чингэлтэй хэмээх билэгтэй сайхан уулын энгэрт Сэлбэ голын сэрүүн сэргэлэн дэнжийг сонгон шав тавьсан гэдэг.

Энэ газар Их хүрээ 1778 онд нүүж ирсэн бөгөөд энэ үеэс Чингэлтэйн нутаг дэвсгэрт хүн ард олноор суурьшиж, хүрээ хийдийн гэр дуган баригдан суурин амьдрал эхэлжээ. Чингэлтэй хайрханаараа овоглосон нэгэн шинэ дүүрэг 1992 онд мэндэлсэн түүхтэй.

Чингэлтэй дүүрэг нь Нийслэлийн хоймрыг эзлэн Баянгол, Сүхбаатар, Сонгинохайрхан зэрэг дүүрэгтэй хил залгаа оршдог бөгөөд 89,3 мянган м.кв газар нутагтай, засаг захиргааны анхан шатны нэгж 19 хороо, 160 мянган хүн амтай. Үүнээс 13 хороо, 130 мянган иргэн нь гэр хороололд, 6 хороо 30 мянган иргэн нь хотын төв хэсэгт амьдардаг. Тус дүүрэгт албан бус боловсролын төв 1, төрийн өмчийн 23, хувийн өмчийн 23 нийт 46 цэцэрлэг байдаг бөгөөд төрийн өмчийн 14, хувийн өмчийн 9 ерөнхий боловсролын сургуульд 30000 гаруй хүүхэд суралцаж, боловсролын салбарт 1492 багш ажилчид ажиллаж байна. Дүүргийн нутаг дэвсгэрт төсөвт байгууллага 231, улсын үйлдвэрийн газар 27, ХК 11, ХХК 9774, хоршоо 47, олон нийтийн байгууллага 158 гэх зэрэг аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаагаа явуулж, 20 нэр төрлийн татварын болон татварын болон татварын бус орлогыг бүрдүүлэн ажиллаж байна.

Дүүргийн нутаг дэвсгэрт Монголын Үндэсний музей, Байгалийн түүхийн музей, Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей, Үлэг гүрвэлийн төв музей, Тэнгис кино театр зэрэг түүх соёл, үзвэр үйлчилгээний газрууд байдаг. Дүүргийн эдийн засгийн гол салбар нь хөнгөн үйлдвэр, барилга, худалдаа, харилцаа холбооны газрууд юм. Тухайлбал Монголын цахилгаан холбоо, Датаком, Мобиком, Сансар, Ньютел зэрэг томоохон компаниудаас гадна Номин, Бишрэлт трейд, Хүчит шонхор хүнсний зах, Нарантуул 2, Марс, Бөмбөгөр зэрэг томоохон худалдаа үйлчилгээний байгууллагууд байрладаг.

Дүүргийн нутаг дэвсгэрт төр захиргааны болон хууль хяналтын байгууллагууд, мөн Монгол банк, Худалдаа хөгжлийн банк, Төрийн банк, Голомт банк, Улаанбаатар хотын банк, Монгол шуудан банк зэрэг банк, санхүүгийн байгууллагууд байдаг. Аж үйлдвэрийн салбарт зоос гоёл, Үнэт цаасны үйлдвэр, Интерпресс, Юнжин, Монгол зэрэг томоохон компаниуд барилгын салбарт Хүрд, Одсалфт, Монтёр, Монижбар, Монсан зэрэг улсын хэмжээний томоохон компаниуд үйл ажиллагаа явуулж байна. Мөн Чингэлтэй дүүрэгт байрлах Тасганы овоо нь 1950-иад оны дунд үе хүртэл хотын ерөнхий төрх байдлыг хардаг гол өндөрлөг цэг байсан бөгөөд Тасганы овооны өвөрт 1919-1920 онд Гэсэр сүмийг байгуулжээ. 1980-аад оны сүүлчээр Тасганы овоог дундуур нь тасдаж зам тавьсан бөгөөд тус замыг Л.Энэбишийн гудамж хэмээн нэрлэжээ.

ОЮУНЛАГ ДҮҮРЭГ

А Хашаа

Хашаандаа сайхан амьдарцгаа

Хашаагаа хэрхэн оновчтой төлөвлөх вэ?

Гэр хороолол, зуслан ногоон бүсэд өрх бүр харилцан адилгүй талбай, хэмжээтэй хашаатай байгаа.

Хашааныхаа аль хэсэгт мод тарьж зүлэгжүүлэх, аль хэсэгт байшингаа барих, Хүүхдийн тоглоомын талбайг хэрхэн шийдэх, цахилгаан, шугам хоолой хаагуур татах гээд олон асуудлыг бодолцож төлөвлөх хэрэгтэй.

Хайрган зүлэгжүүлэлт



Та 0.07 га газраа нийтэд нь зүлэгжүүлбэ гэвэл эдийн засгийн хувьд чамгүй өртөг гаргана. Мөн арчилгаа шаардаж, таны алтан цагаас ихээр хорооно. Энэ бүх төвөгтэй асуудлыг гадаадын улс орнуудад нарийн хайргаар шийдсэн байдаг. Та хүүхдийн тоглоомын талбай, явган хүний зам, авто машины зогсоол, зүлэг, цэцэрлэгжүүлэлтээс бусад ашиглалт багатай талбайгаа таван см зузаантай хайргаар бүрж өгөх хэрэгтэй. /300 м.кв талбайд гурван тонн хайрга орох юм/. Хайрга нь шороо босохгүй, арчилгаа багатай, хямд өртөгтэй, тайвширлыг авчирдаг, бороо эсвэл усанд угаагдахад илүү өнгөлөг, шинэ мэдрэмжийг төрүүлдэг давуу талтай.

Зөвлөмж

Хашаагаа зөв оновчтой төлөвлөх нь ирээдүйд хийх хөрөнгө оруулалтандаа ихээхэн хэмнэлт хийж байгаа юм.



Хашааныхаа нэг талд хүнсний ногоо тарих хэрэгтэй. Энэ нь өрхийн хэрэглээний тодорхой хувийг хангахна.



Хуучин цагийнх шиг модоор хийсэн сандал, сүүдрэвч барих нь оновчтой арга биш. Зай талбай их эзэлнэ. Монгол улс эрс тэс уур амьсгалтай учраас сүүдрэвчийг байнга ашиглаад байдаггүй. Мөн модоор сүүдрэвч барих нь зардал ихтэй. Харин үүнийхээ оронд суулгасан том модоо сүүдрэвч болгон ашиглаж болох юм. Мод тань сүүдрэвч болох хэмжээнд ургаагүй бол та зөөврийн сүүдрэвч, сандлыг хэдэн жилдээ ашиглаж болно.

Хямд бас зөв зүлэгжүүлэлт



Эрүүл амьдралын нууц нь ногоон байгууламж юм. Айл бүр тодорхой хэмжээнд зүлэг, мод, цэцэг тарих нь зүйтэй. 0.07 га газрын 150 м.кв талбайг зүлэгжүүлэхэд хашаан доторх орчин өнгөлөг, цэвэр цэмцгэр харагдана. /Нэг м.кв талбайд 50 гр үр орох юм/. Ингэх нь маш хямд тусна.



Харин нөгөө талд нь амрах, салхилах орчныг нь бүрдүүлээрэй. Ингэхдээ ямар модыг сонгох нь чухал. Сакура мод хамгийн түрүүнд цэцэглэдэг учраас хаврын сайхан мэдрэмжийг танд төрүүлэх нь гарцаагүй. Энэ модноос эхлээд ягаан цэцэг гарч, дараа нь цагаан өнгөтэй болдог. Энэ олон өнгө таны хашаанд амьд орчныг бүрдүүлнэ гэсэн үг.

Байгалийн чулуун замаа донжийг нь олж байрлуулаарай



Амьдрал бол ая тухтай аюулгүй амьдрах орчин юм.

Хашаан дотор хамгийн гол хэсэг бол явган хүний зам. Явах хөдөлгөөний урсгалаа сайн тооцож, замаа барих хэрэгтэй. Цемент, тоосгоор явган хүний зам барих нь мэдээж зардал их. Үүний оронд байгалийн чулуугаар явган хүний зам хийвэл өнгө үзэмжтэй харагдуулдаг. Ингэхдээ чулууныхаа хэлбэр дүрсийг нь оновчтой байрлуулах хэрэгтэй. Чулуугаар хийх боломжгүй бол хуучин банз модыг донжийг нь олж байрлуулж бас болно. Банз, чулуугаар хийсэн замыг өөр газар руу шилжүүлэн байрлуулж болдог юм. Явган хүний замынхаа хоёр талаар нь ногоон байгууламж, хүнсний ногоогоо тарих хэрэгтэй.

Зөвлөмж

Орчин үеийн интерьерийн шийдэл эко орчинг эрэлхийлэх болсон учраас байгалийн бүтээгдэхүүнийг ашиглах нь цаг үеэ олсон тохижуулалт байх болно.

Хашаагаа Ногоон байгууламжтай болгох

Түргэн ургадаг мод, сөөг тарих: Чимэглэлийн ургамлын дийлэнх нь мөчрөөр үржих чадвартай байдаг болохоор мөчрөөр үржүүлсэн 2-4 настай суулгацыг сонговол ашигтай. Харин чимэглэлийн шилмүүст ургамлуудыг голдуу үрээр үржүүлсэн, 1-2 настай суулгацыг өргөн хэрэглэдэг. Хэрэв зүлэгжүүлбэ гэвэл нэг наст болон олон наст ургамлыг сонгох нь зүйтэй. Тэдгээрийг хөгжлийн зөв үе шатанд нь хайчилж бутлах чадварыг дээшлүүлж, ширэглэж ургах нөхцөлийг сайн хангаж өгөх ёстой.

Хөрсний бичил орчин бүрдүүлэх. Цэцэрлэгжүүлэх ажлын эцсийн үр дүн нь хөрсний үржил шим, түүний бичил орчноос шууд хамаардаг. Өөрөөр хэлбэл, ямар ургамлыг ямар хөрсөнд таривал сайн ургах вэ гэсэн хэрэг юм. Энд бидний мэдэх хар шороо, элс хоёр төдийлөн хангалттай биш. Ургамлын үндэсний амьдрах орчинд ямар бичил организмууд амьдарч харилцан ашигтай.

тохиромжтой орчинг бүрдүүлэх асуудал чухал юм. Энэ байдлыг тооцож чаддаггүй учраас тарьсан мод бүр ургаж чаддаггүй юм. Мод үржүүлгийн талбайд сайн ургасан мөртлөө шилжүүлж тарихаар муу ургадаг. Энэ нь тарьсан газрын хөрсний бичил орчин таарахгүй байна гэсэн үг юм.

Таримал хашааг байгуулахдаа цэцэрлэг талбайг хүн, амьтан, мал, тэжээвэр амьтны хөл хөдөлгөөнөөс тусгаарласан байдлаар хийх бөгөөд суулгасан ургамлыг танаж хэлбэржүүлэх эсвэл өөрийнх нь төрхөөр ургуулдаг.

Эмжээрлэсэн сөөгийг тарихдаа замын хашлаган гадна тал, зүлэгийн захаар 0,5 метрээс өндөргүй намхан сөөг, сөөгөнцөр болох жижиг навчит харгана, боролзгоно, жигд зэргийг тарьж болно.

Таримал хана бий болгохдоо ороонго, чөдөр өвчний төрлийн мөлхөө ургамлыг байшин, барилгын хананд бэхлэгч, хэц тогтоон дагуулан ургуулдаг. Бас хээ хуар хэлбэрээр ургуулж болно.

Цэцэрлэгжүүлэлтэнд тарих модыг сонгож авахдаа дараах шалгуур үзүүлэлтүүдийг анхаарах ёстой. Үүнд:

Насны байдал. Чимэглэлийн модлог ургамлууд олон наст ургамал юм. Тухайн сонгосон ургамал хэдэн жил насалж, хэдий хэмжээний титэмтэй болохыг заавал харгалзаж үзэх нь чухал.

Өндөр, нам Чимэглэлийн модыг тарихдаа цаад байгууламжийн гоо үзэмжид тохируулан өндөр намыг бодолцох учиртай. Тайралт хийдэггүй модыг хаана нь тайрч, хэлбэршүүлдэг модыг тарихдаа зөв байрлуулах хэрэгтэй болдог.

Навч Цэцэрлэгийн модыг шилмүүст навчтай (шинэс, гацуур, нарс, арц), илтэслэг буюу хавтгай навчтай (улиас, улиангар, бургас, хус гэх мэтээр) гэж тус бүр ангилж болно.

Навчны өнгө Ургамлын навчны унах хугацаа өөр өөр байхын зэрэгцээ өнгө хувиралт аажим олон өнгө үзүүлдэг.

Титэм Ургамал бүрийн газрын дээд хэсгийн хэлбэр дүрс өөр өөр байдаг. Цэцэрлэгийг ямар зориулалтаар байгуулж байгаагаас хамаарч титмийг бас янз бүрээр хэлбэржүүлж болдог.

Цэцэглэх үеийн үргэлжлэх хугацаа

Хавар эрт цэцэглэдэг, зуны турш цэцэглэдэг ургамлууд бий.

Үндэсний системийн байдал

Ямар ч ургамлын газрын дээд хэсэгтэй тэнцүү хэмжээний үндэсний систем байна гэдгийг ямагт санах хэрэгтэй. Тийм учраас ургамал тарих зайг тохируулах нь чухал. Бас улиас мэтийн ургамлууд үндсээрээ үрждэг. Байшин, барилгад хэт ойрхон таривал газар доорх шугам сүлжээнд аюул учруулж болох юм.

Та хашаандаа мод тарьсан уу?



Монос

Монос сайхан үнэртэй жорлон буюу ариун цэврийн байгууламжийн ойролцоо байх нь илүү тохиромжтой байдаг. Монос нь байгальд голын хөндий, шугуй горхины эрэг, хусан төгөл, ам хавцлын ёроол хажуу энгэрт ургах 3-7 метр өндөр сөөг юм. Газрын хөрснөөс дээш богинохон иш гарч тэр нь цаашдаа бутлан салаалж сөөг хэлбэрийг үүсгэнэ. Яст жимс нь шүүсэрхэг бөмбөлөг хэлбэртэй тас хар өнгөтэй, чийглэг, хүйтэнд тэсвэртэй. Цэцэглэх тавдугаар сарын сүүлч зургадугаар сарын эхээр цэцэглэдэг. Цэцэглэх үедээ сайхан үнэртэй. Үр жимс нь наймдугаар сард боловсорно. Үр боловсорсон үедээ үзэсгэлэнтэй өнгө хувиргадаг гоёл чимэглэл болон жимсний зориулалтаар тарималжуулна. Таналт хяргалт сайн даана. Хэлбэржүүлэхэд нэн үзэмжтэй. Мод хооронд 3-4 метр зайтай тарих тохиромжтой. Нүхэнд мод тарих аргатай ижил байна.



Шилмүүст


Шилмүүст мод нь бусад модлог ургамлуудын дотроос анхилам үнэр ялгаруулдаг онцлогтой. Тэр бодис нь агаарын бичил организмуудыг (ханиад томууны бактери, савханцар) устгадаг. Боломжтой бол мөнх ногоон шилмүүст ургамал, навчит бол навч нь олон өнгө үзүүлж чадах, бас үр тоос нь орчныг бохирдуулахгүй байх нөхцөлийг тооцох хэрэгтэй. Эм улиасыг чимэглэлд ихээр хэрэглэснээр үүдэж зургадугаар сард түүний үр ихээхэн төвөг учруулдгийг санах хэрэгтэй. Чихэрлэг ургамал таривал шавж хорхой ихээр цугларах тохиолдол бий.



Агч мод

Агч мод нь олон иш үүсгэн дугуйвтар титэм хэлбэртэйгээр 3-7 метр өндөр ургах гоёмсог навчтай бэсрэг мод юм. Агч мод нь олон иш үүсгэн дугуйвтар титэм хэлбэртэйгээр 3-7 метр өндөр ургах гоёмсог навчтай бэсрэг мод юм. 4-5 настайгаасаа эхэлж үрлэх ба тавдугаар сарын сүүлчээр цэцэглэж есдүгээр сарын эхээр үр боловсорно. Агчны бүх зүйлүүд ганд тэсвэрлэх чадвар дунд зэрэг, хүйтэнд тэсвэртэй. Өсөлт ургалтынхаа эхний үедээ сүүдэрлэг орчинд ургахдаа сайн. Үржил шим сайтай. Элсэрхэг хөнгөн хөрсөнд сайн ургадаг. Үрээр үржүүлэхэд хялбар үржинэ. Гоёл чимэглэлийн зориулалтаар ганц нэгээр болон бусад зүйлийн мод буттай хослуулан төгөл, гудамжны хажуу зам дагуулж цуваа хэлбэрээр ургуулахад нэн зохимжтой. Таналт хяргалт сайн даана. Хэлбэржүүлэхэд нэн үзэмжтэй. Мод хооронд 3-4 метр зайтай тарих тохиромжтой. Нүхэнд мод тарих аргатай ижил байна.

“Өнөөдөр үрээ тарьж Маргааш ургацаа хураацгаая.”



Шар хуайс мод



Мөчир ногоон саарал. Найлзуур нь ногооноос шаргал хүрэн. Навчны дагавар өргөслөг. Навчис өдлөг нийлмэл Навчинцар дөрөв, найман хос зууван цэцэг ганц нэгээрээ юм уу, 5 хүртэл бөөнөөр байрлана. Цэцгийн шилбэ 2-5 см урт, үзүүр хэсэгтээ үетэй. Цоморлог өргөн хонхорхуу. Дэлбэ шар. Буурцаг шугаман бортгорхуу, 3,5-6 см урт, нүцгэн. Цэцэглэх, үрлэх хугацаа 6, 7, 8 дугаар сар Таналт, хяргалт сайн даана. Хэлбэржүүлэхэд нэн үзэмжтэй. Мод хооронд 3-4 м зайтай тарих тохиромжтой. Нүхэнд мод тарих аргатай ижил байна.

Бүйлс мод



алаархаг сарвагар мөчиртэй, залуу найлзуур улаавтар хүрэн, үсэрхэг, их өргөстэй хатгууртай. Цэцэг ганц нэгээр юм уу хааяа богиносон найлзуур дээр хэд хэдээрээ багцалж байрлана. Дэлбэ ягаан, тонгоруу өндгөрхүү 5-7 мм. Навчлахын өмнө дэлгэрдэг. Яст жимс өргөн өндгөрхүү бөөрөнхий. 1,2-1,5 см урт, нэг см өргөн, үсэрхэг. Цэцэглэх, жимслэх хугацаа 5-6, 8-9 сар. Мод хооронд 3-4 м зайтай тарих тохиромжтой. Нүхэнд мод тарих аргатай ижил байна.

Өрөл бөөрөнхий



Найлзуур нь удаавтар хүрэн, нүцгэн. Навч нь өндгөрхүү богино зууван 2,5-8,0 см урт, 1,3-5,0 см өргөн, навчны шилбэ 1,2-4,0 см урт. Цэцэг нь 4 8-аар нийлж цагаан өнгийн шүхэр үүсгэнэ. Үр жимс бөөрөнхий, улаавтар туяа бүхий шаргал өнгөтэй, исгэлэн амттай. Ургалт тавдугаар сарын эхнээс есдүгээр сарын сүүлч хүртэл, найлзуурын өсөлт тавдугаар сарын сүүлчээр наймдугаар сарын сүүлч хүртэл үргэлжилнэ. Зургадугаар сард цэцэглэж, есдүгээр сарын дундаас наймдугаар сарын сүүлч хүртэл үргэлжилнэ. Тавдугаар сард цэцэглэж, зургадугаар сард үрлэж эхлэн наймдугаар сарын сүүлчээр үр жимс нь боловсорч гүйцдэг. Үрээр ургуулсан 2 настай тарьцыг бойжуулгын талбайд хоёр жил торниулаад байнгын талбайд шилжүүлнэ. Ногоон байгууламжид ганц нэгээр болон хэсэг бүлгээр, хамгаалалтын зурвас, амьд хашлаганд, хөрс хамгаалах зориулалтаар суулгахад тохиромжтой.

Долоогоно




олоогоно бараан хүрэн найлзууртай, 1,0-2,5 см урт өргөстэй. Навчны илтсэний хоёр тал ихэвчлэн нүцгэн, заримдаа дээд тал хааяа хоёр тал нь ширүүн үстэй. Навчны илтэс гонзгойвтор өндгөрхүү хэлбэртэй. Баг цэцэг нь 7-20 ш цэцэгтэй, жимс бөөрөнхий буюу бага зэрэг гонзгойвтор улаан 3-4 ястай доод талдаа хонхорхойтой. Ургалт тавдугаар сарын эхний арав хоногоос 9 сарын сүүлч хүртэл, найлзуурын өсөлт тавдугаар сарын дундаас наймдугаар сарын сүүлч хүртэл үргэлжилнэ. Тавдугаар сард цэцэглэж, зургадугаар сард үрлэж эхлэн наймдугаар сарын сүүлчээр үр жимс нь боловсорч гүйцдэг. Үрээр ургуулсан 2 настай тарьцыг бойжуулгын талбайд хоёр жил торниулаад байнгын талбайд шилжүүлнэ. Ногоон байгууламжид ганц нэгээр болон хэсэг бүлгээр, хамгаалалтын зурвас, амьд хашлаганд, хөрс хамгаалах зориулалтаар суулгахад тохиромжтой.

В Хог хаягдал

Хогоо эх үүсвэр дээр нь ангилж хэвшилцгээ

Хог хаягдал гэж юу вэ?

2017 онд батлагдсан “Хог хаягдлын тухай” хуулиар “Өмчлөгч этгээд нь ашиглахаа больсон эд, юмс, материалыг хог хаягдал” гэж тодорхойлж байна.




Хогоо хэрхэн ангилж хаях вэ?

REDUCE Хамгийн түрүүнд бууруул	REUSE Мөн дахин ашигла	RECYCLE Гурав дахин боловсруул
1 Хог хаягдлыг бууруулахдаа аливаа зүйлсийг сайтар бодож болгоомжтой хандах хэрэгтэй	2 Боломжийн хирээр дахин ашиглагдах байх хэрэгтэй	3 Нөөцийг бий болгохын тулд хог хаягдлыг дахин боловсруулах хэрэгтэй.
- Хэт их хоол хүнс худалдан авахгүй байх. - Дэлгүүрээр үйлчлүүлэхдээ өөрийн уутыг ашигладаг байх - Идэвхитэй худалдан авалт хийхээ зогсоох. - Эвдэрсэн эд зүйлээ аль болох боломжоороо сэлбэж засдаг байх.	- Хуучин эд зүйлээ хаялгүйгээр хэрэгтэй нэгэнд өгөх. /өглөгч байх/ - Дахин ашиглах боломжтой сав баглаа боодолтой бүтээгдэхүүнийг худалдан авдаг байх. Жишээлбэл: Архи, ундааны шил савыг дэлгүүрт буцаан тушаах, эс бол борлуулах. - Нэг удаагийн хэрэгслээс татгалзаж олон дахин ашиглах бүтээгдэхүүнийг хэрэглэх.	- Дахин боловсруулсан сав баглаа боодолтой бүтээгдэхүүнийг худалдан авдаг байх. - Манай улсад дахин боловсруулагдаж байгаа картон цаас, хуванцар лаазыг гэх мэт эх үүсвэр дээр ангилан ялгаж дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлдэг байх.

Хог хаягдлыг дараах байдлаар ангилан ялгана.



Хог хаягдлыг ангилан хаяхдаа овор хэмжээг заавал багасгаж хаяна.



Мөн ангилан ялгаж хаяхдаа хогны овор хэмжээг бууруулан хаях нь зүйтэй юм. Хог хаягдлын овор хэмжээ 50-90% хүртэл бууруулах боломжтой бөгөөд овор хэмжээг бууруулснаар:

- ✓ Хог тээврийн хог ачилтын тоо цөөрч цаг хугацааг хэмнэж, хөдөлмөрийг хөнгөвчилнө.
- ✓ Хогны сав, хогны уут амархан дүүрэхгүй.
- ✓ Тээвэрлэлтийн болон бусад холбогдох зардлууд буурна.

Хог хаягдлаа ямар хуваарийн дагуу ачуулах вэ?

“Хог хаягдлын үйлчилгээ нийлүүлэх” гэрээнд заагдсаны дагуу орон сууц хороололд 7 хоногт 2-3 удаа хог ачиж цэгийн хогийг ачиж тээвэрлэдэг бол гэр хороололд сард 2-4 удаа хог ачиж тээвэрлэдэг. Хог хаягдлыг тухайн дүүргийн засаг даргатай гэрээ хийсэн Хог хаягдлын үйлчилгээний байгууллагууд буюу ТҮК ачиж тээвэрлэдэг.



Хог хаягдлын хураамжаа хэрхэн төлөх вэ?

Хог хаягдлын тухай хуулийн 41 зүйлд заасны дагуу иргэн бүр хог хаягдлын хураамжийг заавал төлөх үүрэгтэй. Та гэр хороололд оршин суудаг бол эрчим хүчний хэрэглээний төлбөрийн хамт, орон сууцанд оршин суудаг бол СӨХ-ийн төлбөрийн хамт тогтмол хугацаанд заавал тушаагаарай.

Хог хаягдлын талаарх асуудлаар та хэнд хандах вэ?

Тухайн иргэн орон сууцанд амьдардаг бол орон сууцны СӨХ-дөө хандах бөгөөд СӨХ хог ачиж тээвэрлэх гэрээтэй компанидаа хандан уг асуудлыг шийдвэрлэх болно. Тухайн асуудал олон нийтийг хамарсан бол СӨХ нь тухайн харьяалах хороондоо хандана. Гэр хороололд амьдардаг иргэн шууд тухайн амьдардаг хороондоо хандах бөгөөд хороо уг асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллана.

Хүнсний болон бусад органик хаягдлаар хэрхэн бордоо хийх вэ?

Бордоо гэж юу вэ?

Бидний идэх тариалангийн хүнсийг тэжээх шимт хөрс нь бордоо ба цэвэр агаар бэлэглэгч ногоон ургамлыг тэтгэгч юм. Энэ нь химийн бодис биш, органик буюу байгалийн аргаар бий болсон байх нь хамгийн сайн бордоо юм.

Хүнсний хаягдлаар бордоо хийх хэд хэдэн арга байдаг. Ашиглаж болох хүнсний хаягдалд

- ✓ Ногооны хальс, жимсний хальс ногооны гол үлдэгдлийг жижиглэн хийх өндөгний хальс
- ✓ Цай, кофений шаар /Цаасан ууттайгаа байж болно/
- ✓ Цаас, модны үртэс, бор картон цаас өндөгний картон сав багтдаг байна.
- ✓ Ургамлын хөрс нь тогтмол чийгтэй байх ёстой байдаг ба цаас хөрсний балансыг тохируулж өгнө. Хэтэрхий усархаг болчихвол цаас нэмнэ гэх мэтээр цаасыг хэрэглэнэ. Мөн модны үртэс байж болно. Эхлээд савныхаа доор дэвсгэр болгон цаас дэвсэнэ, дэвсэхдээ агаартай хөвсийлгээд том том ураад дэвсэж болно.

Органик бордоо

Бүрэн ялзарсан бууцаар жил бүр хөрсийг бордвол хөрсний үржил шим тогтвортой байх бөгөөд нэмэгдэх ч боломжтой. Бордохдоо ногооныхоо талбайг сайн тэгшлээд бууцыг хөрсөн дээрээ 5см орчим зузаантайгаар жигд тарааж хөрсний 20-25см-ийн гүнд хольж өгнө. Хэрэв бүрэн ялзарсан бууц олдохгүй бол хагас ялзарсан ба шинэ бууцыг ч хэрэглэж болно. Гэхдээ 6-8см зузаантайгаар тарааж бордоно. Учир нь удаан ялзарч зарим хэсэг нь 2-3 дахь жилдээ ашиглагдана. Харин энэ үед ургах зэрлэг ургамлыг цаг алдалгүй устгах мөн хортон шавьжийг дайжуулах арга ажиллагааг урьдчилан төлөвчиж эрсдэлийг даван туулах бэлтгэлээ хангасан байх хэрэгтэй.

Шингэн бордоо

Үүнийг ургамлын үлдэгдэл, хөрс, мал амьтны ялгадас, махнаас бусад органик бүтээгдэхүүний үлдэгдлээр бэлтгэх ба мал амьтны ялгадсаар бэлтгэсэн бордоо нь шууд ургамалд ашиглагддагаараа ашигтай. Харин ургамал, хөрс, жимс, өндөгний хальс зэргээр бэлтгэсэн жүүс нь хөрсний ашигтай микро организмыг тэжээж байгалийн үржил шимийг нэмэгдүүлдгээрээ илүү ач холбогдолтой бөгөөд энэ нь сүүлийн үеийн эрчимжсэн шинэ арга технологи юм.

Багсармал /холимог/ бордоо

Бууцыг зөв ялзруулахгүй бол хэт халж ургамалд ашигтай органик хэсэг нь шатаж устдаг. Иймд ашигтай тэжээлийн бодисыг авч ашиглахад багсармал бордоо бэлтгэж хэрэглэх нь илүү ач холбогдолтой. Багсармал бордоо нь:

- ✓ Богино хугацаанд ургамалд эрчимтэй ашиглагддаг
- ✓ Эрүүл мэндэд хор нөлөөгүй
- ✓ Өртөг багатай
- ✓ Ургацыг тогтвортой нэмэгдүүлэх боломжтой
- ✓ Гарын доорх материалаар хийх боломжтой
- ✓ Махны төрлөөс бусад ялзарч болох бүх хог хаягдлыг ашиглах боломжтой зэргээрээ илүү ач холбогдолтой

Багсармал бордоог бэлтгэх

Хамгийн доод үед нь сүрэл, модлог зэрлэг ургамлын үлдэгдэл зэрэг хөнгөн сэвсгэр материалыг 8-10см орчим дэвсэнэ. Суурийн өргөн 1-1,2 м орчим, урт нь таны хүссэн хэмжээгээр байна. 2 дахь үед нь 5см орчим ялзарч болох ахуйн хаягдал бусад органик материал хийнэ. Дараагийн үед нь бууц 8-10см хийнэ. Ийм байдлаар үелүүлэн хийсээр овоолгын өндрийг 1м болгоно. Овоолгыг хийх явцдаа үе бүрийг усаар шүршиж бага зэрэг норгоно. Овоолгыг хийж дуусаад нийлэг хальсаар хучна. Хучсанаас хойш бордоо түргэн боловсроход чийг ба доторх температурыг хянаж байх нь хамгийн чухал байдаг. Боловсрох чийг нь 70% орчим, доторх температур нь 60-70 градус байна. Багсармал бордоог боловсруулах явцад сар тутам хольж хутгах ба зөв боловсорсон бордоог 3 сарын дараагаас эхлэн хэрэглэнэ. Бордоо хэрэглэхгүй байснаас ургац алдахаас гадна төрөл бүрийн элемент дутагдаж ургамал өвчлөхөд хүрдэг.

С Ус, дулаан, цахилгаан

Ус эрчим хүчээ хэмнэцгээе.

Бид ямар тарифаар ус, дулаан, цахилгааны төлбөрөө төлдөг вэ?

Ахуйн хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчдийн ангилал			Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Орон сууцны халаалт (оюутны байр, подвал, "0" -ийн өрөөний халаалт хамаарна)			Төг/м2	506.00
				Төг/ГДж	3,421.00
2	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Хүний тоогоор	Халаалтын улиралд	Төг/хүн	1,870.00
			Халаалтын бус улиралд	Төг/хүн	2,806.00
		Усны зарцуулалтаар		Төг/м3	1,632.00
		Хэмжүүрээр		Төг/ГДж	3,421.00
3	Ахуйн хэрэглэгчдийн дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф				
3.1	40м2 хүртэл талбайтай айл өрх			Төг/Сар	3,300.00
3.2	41м2-аас 80м2 хүртэл талбайтай айл өрх			Төг/Сар	5,500.00
3.3	81м2 -аас дээш талбайтай айл өрх			Төг/Сар	11,000.00

2021 оны 5 дугаар сарын байдлаар мөрдөгдөж буй үнэ тариф

Цахилгааны чадлын тариф

АЙЛ ӨРХӨД БОРЛУУЛАХ ЦАХИЛГААНЫ ТАРИФ

№	Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Энгийн тоолууртай	Төг/м2	506.00
а	Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц хүртэлх хэрэглээ	Төг/кВт.ц	110.49
б	Сарын нийт хэрэглээний 151 кВт.ц болон түүнээс дээших хэрэглээ	Төг/кВт.ц	130.29
2	2 тарифт тоолууртай		
а	Өдрийн хэрэглээ /өглөөний 06.00 цагаас шөнийн 21.00 цаг хүртэл/		116.39
б	Орой, шөнийн хэрэглээ /оройн 21.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл/		89.19
з	Сарын суурь тариф		2.000.0

Ахуйн тоолуургүй цахилгаан хэрэглэгчдийн төлбөр тооцох сарын дундаж хэрэглээ

Ахуйн тоолуургүй цахилгаан хэрэглэгчдийн төлбөр тооцох сарын дундаж хэрэглээг төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Ангилал	Хэмжих нэгж	Сарын хэрэглээ
1	Айл өрх	кВт.ц	350

Сэргээгдэх эрчим хүчийг дэмжих тариф

Сэргээгдэх эрчим хүчийг дэмжих тарифыг 23.79 төг/кВт.ц -аар тооцно

Усны тариф

АЙЛ ӨРХӨД БОРЛУУЛАХ ЦАХИЛГААНЫ ТАРИФ

№	Үйлчилгээний нэр		Хэмжих нэгж	Үнэ НӨАТ ороогүй	НӨАТ	Нийт үнэ /НӨАТ/ тэй	Тушаал шийдвэр
1	Цэвэр ус	тоолууртай	Төг/м3	710.00	710.00	781.00	ХСУХАТАУЗЗ-ийн 2019 оны 23 дугаар тогтоол /05 сарын 01-нээс мөрдсөн/
		тоолуургүй	Төг/м3	1040.00	1040.00	1144.00	
			Төг/хүн	6240.00	6240.00	6864.00	
2	Бохир ус	тоолууртай	Төг/м3	580.00	58.00	638.00	
		тоолуургүй	Төг/м3	760.00	76.00	836.00	
			Төг/хүн	4560.00	456.00	5016.00	
3	Орон сууцны айл өрхийн усны үйлчилгээний суурь хураамж		Өрх/сар	3000.00	300.00	3300.00	
4	Хогны хураамж		Өрх/сар	2000.00		2000.00	НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2006 оны 08 сарын 24-ний өдрийн 182 д

Ус дулаан, цахилгаантай холбоотой гэмтэл гарвал хаашаа хандах вэ?

Иргэн та ус, дулаан, цахилгаантай холбоотой гэмтэл гарвал мэдээллийг өөрийн оршин суух хорооны “Орон сууц ашиглалтын контор” –д яаралтай холбогдож мэдээллээрээ.

№	Байршил	Харьяа салбар компаниуд	Ээлжийн инженер Диспетчер
1	Сүхбаатар дүүрэг	“Энх тулга –Өргөө” ОНӨААТҮГ	321641
		“Зүүн сэлбэ –Өргөө ОНӨААТҮГ	324097
2	Чингэлтэй дүүрэг	“Чин хүрээ –Өргөө” ОНӨААТҮГ	70115764
		“Бат дулаан –Өргөө” ОНӨААТҮГ	70115026
3	Хан-Уул дүүрэг	“Түшээ дунд гол –Өргөө” ОНӨААТҮГ	341826
4	Баянзүрх дүүрэг	“Дэнж сансар өргөө” ОНӨААТҮГ	450697
		“Их алтан тэвш –Өргөө” ОНӨААТҮГ	455025, 452186
		“Дэнж найрамдал –Өргөө” ОНӨААТҮГ	454050
		“Улаанхуаран –Өргөө” ОНӨААТҮГ	70156722
5	Баянгол дүүрэг	“Ганга Өргөө “ ОНӨААТҮГ	244283
		“Батбаян бүрд” ОНӨААТҮГ	244780
		“Ган зам –Өргөө” ОНӨААТҮГ	367152
		“Ашид мөнх –Өргөө” ОНӨААТҮГ	687491
		“Баруун их нарлаг –Өргөө” ОНӨААТҮГ	70120203
		“Гандан дэнж –Өргөө” ОНӨААТҮГ	70149711
		“Хүрээ дэнж –Өргөө” ОНӨААТҮГ	77065560
		“Шинэ хороолол –Өргөө” ОНӨААТҮГ	70122017, 70132017
6	Сонгинохайрхан дүүрэг	“Өнөр тулга –Өргөө” ОНӨААТҮГ	682966
		“Өнөр энх –Өргөө” ОНӨААТҮГ	682484
		“Таван шар –Өргөө” ОНӨААТҮГ	70180015
		“Таван шар –Өргөө” ОНӨААТҮГ	77440079

Мөн Эрчим хүчний яам, Диспетчерийн үндэсний төв ХК, Нийслэлийн Шуурхай удирдлага зохицуулалтын мэдээллийн төв /310005/ болон өөрийн байгууллагын удирдлагуудад тогтмол мэдээлэл өгч, хэрэглэгчдээс гомдол саналыг 24 цагийн турш 343047 дугаарын утсаар авч, шуурхай барагдуулж ажиллах юм. Цахилгаан шугам сүлжээний газрын диспетчер, шуурхай ажиллагааны бригад 24 цагаар ажиллаж, цахилгааны гэмтэл саатлын талаар гарсан гомдол саналыг 70047004 дугаарын утсаар авч ажиллана. УСҮГ болон, Зөөврийн ус хангамжийн алба, Салбаруудын нэгдсэн албадууд дээр хариуцлагатай жижүүрүүд ажиллах бөгөөд ачаалал ихтэй цэгүүдэд салаалагч гаргаж ус түгээж үйлчилнэ. Үйлчилгээний талаарх санал гомдол, дуудлагыг 70157066, 70157016, Зөөврийн ус хангамжийн албаны 70157025 дугаарын утсуудаар тогтмол авч үйлчилнэ.

Хөгжлийн гарц - Хамтрахад оршино.

Эрчим хүчээ хэмнэх нь эх орондоо оруулж буй бодит хувь нэмэр юм

Эрчим хүч хэмнэх энгийн арга

Гэрийн нөхцөлд цахилгаан эрчим хүч хэмнэх олон арга байдаг хэрэглээгээ ухаалгаар зохицуулж, өрхийн төсвөө хэмнэж байгаа цахилгаан хэрэглэгчид олон болж байгаа гэдэгт итгэлтэй байна. Гал тогооны орчинд болон хоол бэлтгэхэд цахилгаан эрчим хүчээ хэрхэн хэмнэх талаар зөвлөгөөг хүргэе.

 Цахилгаан зуухны тавилыг хоолоо буцалтал хамгийн их дээр нь буцалж эхэлмэгц бага руу нь шилжүүлэх маягаар хоол хийх цагаа нэмэхгүйгээр эрчим хүчээ хэмнэж болдог. Хоол хийх үедээ савныхаа тагийг тавихаа бүү мартаарай. Ингэснээр та эрчим хүчний хэрэглээгээ 2.5 дахин багасгана	 Хоолны савны ёроолын диаметр цахилгаан зуухны халах аль болох адил хэмжээтэй, хавтгай, цэвэрхэн, гөлгөр ёроолтой байх тусам эрчим хүний хэрэглээ 60 хүртэл хувиар буурна	 Хүнсний ногоог болгохдоо аль болох бага усанд жигнэх, чанах аргыг хэрэглэж байгаарай. Энэ нь эрчим хүч хэмнэхээс гадна эрүүл мэндэд ч тустай
 Түргэн буцалгагч нь таны хоол бэлтгэх цаг хугацааг 3 дахин хэмнээд зогсохгүй цахилгаан зарцуулалтыг 2 дахин бууруулдаг	 Цахилгаан зуухны халах хэсэг шатсан эсвэл удаан халдаг болсон бол хурдан засуулаарай. Гэмтэлтэй цахилгаан зуух хоол удаан болгодогос гадна цахилгаан зарцуулалт 50 хувиар нэмнэ	 Цахилгаан данх болон ус буцалгагчиндаа зөвхөн хэрэгтэй хэмжээгээр усаа тааруулж буцалгаарай
 Усны чанараас хамаарч цахилгаан данх болон ус буцалгагчны дотор үүсдэг чулуужсан хэсгийг сайн цэвэрлэж байгаарай. Цэвэрхэн дотортой буцалгагч цахилгаан зарцуулалтыг 20 хувиар хэмнэнэ	 Хөргөгч нь жилд чадлаасаа хамаараад 500-1000кВт.ц цахилгаан эрчим хүч хэрэглэдэг	 Хөргөгчний цахилгаан зарцуулалтыг багасгахын тулд дараах аргыг хэвшүүлээрэй

Анхааруулга

- ✓ Хөргөгчийг хананд тулгаж байрлуулж болохгүй
- ✓ Хөргөгчинд халуун зүйл хийхгүй байх
- ✓ Хөргөгчний дунд хэсэгт агаар солилцох зай үлдээнэ
- ✓ Мөстсөн хөргөгч цахилгаан зарцуулалтыг 5 хувиар нэмдэг тул үргэлж цэвэрхэн байлгаарай

Ус хэмнэх олон арга бий тэд бүгд таниас эхэлдэг

Ус хэмнэх энгийн аргууд

 Аяга таваг, тогоо шанагаа угаахдаа сайтар үрж зүлгэхдээ усаа хааж бай. Дараа нь цэвэр усаар зайлж бай.	 Хүнс ногоогоо гоожиж буй усаар бус усаар дүүргэсэн саванд цэвэрлээд дараа нь цэвэр усаар зайл	 Стаканд ус хийж аваад шүдээ угаах
 Шүршүүрт орохдоо усаа хэмнэх, ус бага хэрэглэдэг шүршүүртэй болох	 Гар нүүрээ угаахдаа усаа хэтэрхий ихээр гоожуулахгүй байх	 Саванд ус хийж аяга тавгаа угаах, крантнаас гоожуулж угаахгүй байх
 Бие засах өрөөний усыг олон дахин татахгүй байх	 Ус дусалж байгаа крантуудыг хаах	 Усыг хэмнэх хамгийн үр дүнтэй арга нь тоолууржуулах юм

Хөрс

Хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлье

Та нүхэн жорлон ашигласаар л байна уу?

Улаанбаатарын гэр хорооллын гүний усанд нитратын бохирдол их байгаа нь нүхэн жорлонтой холбоотой. Тиймээс үүнийг шийдвэрлэх ганц арга нь жорлонгоо өөрчлөх, хөрс рүү шууд ялгадсаа шингээхгүй байх, мөн угаадсаа шууд асгадаг явдал нь шинэ төрлийн органик бохирдлын эх үүсвэр бий болгох аюултай. Нитратаар бохирлогдсон ус хүний биед орсныхоо дараа NO2 болон хувирч, хүчилтөрөгчийг эд эсэд хүргэхэд саад болдог аж.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын тооцоогоор нэг хүн өдөрт дунджаар 200 грамм өтгөн, 1.5 литр шингэн ялгадас ялгаруулдаг. Нийслэл Улаанбаатарт манай улсын нийт хүн амын хагас нь буюу 1.4 сая хүн аж төрдөг. Үүнээс гэр хороололд 218 мянга гаруй өрх амьдардаг ба манай хотод 386,000 нүхэн жорлон бий болжээ. Үндсэндээ нийт хүн амын тал нь нийслэл хотдоо төвлөрдөг манай улсын хувьд нүхэн жорлонгийн бохирдолт нь үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх хэмжээний нэн чухал асуудал болсон байна.

Танд санал болгох ахуйн шаардлага хангасан жорлонгийн шийдлүүд

шийдлүүдийн талаарх мэдээллийг www.minishiidel.mn сайтаас үзнэ үү

Иргэдийн хамгийн их сонгосон эко жорлонгийн таван технологи:

1. Соруулдаг жорлон
2. Говийн хуурайшуулан хатаагч жорлон
3. Саванд хуурайшуулан хатаагч жорлон
4. Газарт бордоошуулагч жорлон
5. Саванд цуглуулж, бордоошуулах жорлон

Та хэрэглэж буй өмхий үнэртэй, бохир, ялаа батгана болон элдэв нян бактерийн үүр болсон жорлондоо дөрвөн үндсэн өөрчлөлт буюу нүх, тавцан, бүхээгийг өөрчилж, агааржуулалтыг шийдсэнээр эко болон хувирах бүрэн боломжтой юм байна.

Шинэ шийдэл ба Биоланы Симплетт жорлон

Ялгадсыг хуурайшуулан хадгалдаг уг жорлонг дотор, гадна, хөдөө орон нутаг, гэр, байшинд хаана ч хэрэглэж болох гэнэ. Тог, ус ашиглахгүй. Мөн угсарч суурилуулахад хялбар, хэрэглэхэд тухтай энэхүү жорлон нь өтгөн, шингэн ялгадсыг салгаж хадгалдаг байна. Шингэнийг тусгай сав руу юулж оруулах бол өтгөнийг био ууттай саванд цуглуулна. Уг жорлонг Монголтой төстэй хүйтэн уур амьсгалтай Финланд улсад үйлдвэрлэсэн бөгөөд суултуур нь стандарт хэмжээтэй, өвөл хайрахгүй, хөлдөхгүй полистирол материалаар хийгдсэн, хүүхэд, хөгшид, хөгжлийн бэрхшээлтэй иргэн гээд гэр бүлийн бүх гишүүн хэрэглэх боломжтой аж.

Хөрсний бохирдлыг бууруулахад таны оролцоо

1. Угаадсаа ил задгай асгахгүй байх. Угаадас нь гэр хороолол амьдардаг айлуудад төдийгүй орон сууцны айлуудад хамааралтай. Орон сууцанд амьдардаг хүмүүс орчныхоо гадаахивс, автомашинаа угааж буй дүр зураг дулааны улиралд их элбэг харагддаг.
2. 1900-аад оны хоцрогдсон газар ухаж жорлон гаргах технологиос татгалзах. Орчин үеийн боловсон жорлон ашигласнаар дулааны улиралд ялаа зэрэг шавьж шаважгүй тав тухтай бие засах боломжтой.
3. Хогоо ил задгай хаяхгүй байх. Ахуйн хог хаягдлаа зориулалтын хогийн уутанд савлаж, боож хаяж хэвшээрэй.
4. Автомашинаа ил задгай угаахгүй, ус зайлуулах шугамтай зориулалтын угаалгын газраар үйлчлүүлэх. Автомашин угаалгын жижиг газруудын ихэнх нь ус зайлуулах шугамгүй байдаг.
5. Автомашинаа ил задгай угаахгүй, ус зайлуулах шугамтай зориулалтын угаалгын газраар үйлчлүүлэх. Автомашин угаалгын жижиг газруудын ихэнх нь ус зайлуулах шугамгүй байдаг.
6. Нэгэнт хөрсний бохирдол ихтэй энэ үед дулааны улиралд хүүхдүүдээ гадаа тоглуулахдаа ариун цэврийг сайн сахиулах, хоол идэхийн өмнө, бие зассаны дараа гараа тогтмол угааж хэвших хэрэгтэй.

MNS5924:2015 нүхэн жорлонгийн стандарт

1. Жорлонгийн нүх хөрсний уснаас дээш 2м-ээс багагүй түвшинд байна
2. Хөрсний усны түвшин өндөр, намагтай газар нүхийг хүчитгэж доторлоно
3. Хүчитгэсэн доторлогоотой нүх нь ээлжлэн ашиглах зэрэгцээ нүхтэй байж болно
4. Хад чулуутай хөрсөнд нүхийг хүзүүвч хэлбэрээр газраас дээш өндөрлөж болно
5. Нүхний эзэлхүүнийг ашиглах хүний тоо, ашиглахаар төлөвлөсөн жил, суурь коэффициент 0,06м³ -ийн үржвэрээр тооцоолно
6. Нүхэнд ариун цэврийн хэрэгсэл, хог хаягдал хийхгүй байх нь зүйтэй



Хашаан доторх хөрсөө хэрхэн эрүүлжүүлж ногооруулах вэ?



Хашаанд байх хамгийн гол зүйл бол ширдэг шиг зөөлхөн ногоон зүлэг. Гэхдээ хөрсний болон орчны бохирдол, арчилгаа зэргээс үүдэн зүлэг халцрах, шарилж, хогийн ургамал ургах зэрэг сөрөг үзэгдлүүд гарах нь олонтаа. Иймээс тогтмол арчилж, зүлгээ засаж янзалж байх хэрэгтэй. Хэрэв боломжтой бол зүлгээ тогтмол биш ч гэсэн хааяадаа тэгшилж байх хэрэгтэй бөгөөд 5 см-ээс багасгалгүй тэгшлэхийг танд зөвлөө. Мөн зүлгийг суулгаж арчлахад зардал их ордог учир тодорхой хэмжээний газарт зааг гарган тарих нь илүү цэвэрхэн, цэгцтэй харагдахаас гадна арчилгаанд ч хялбар. Нөгөө талаар ургамлын сүрэл болон хайргаар тохижуулах шийдлийг хүмүүс сүүлийн үед ихээр хэрэглэх болсон бөгөөд хайрганы хувьд тоос босохгүй, хямд өртөгтэй, арчилгаа багатай зэрэг олон давуу талтай байхад сүрэл нь хөрсөн дэх чийгийг хадгалж, мөн гадна орчны бохирдол, чийгээс хамгаалдаг давуу талтай.

Хашаанд зүлэг тарих заавар зөвөлгөө.

Та юуны түрүүнд зүлэг тарих талбайн хөрсийг бэлтгэх хэрэгтэй. Зүлэг тарих талбайн хөрсийг бэлтгэхийн тулд дагтаршсан газрыг хүрз, жоотуу, тармуураар 15-20 см гүн ухаж том чулуу, дунд зэргийн чулуу, зэрлэг ургамлын үндэс зэргийг шигшин авах хэрэгтэй. Үүний зэрэгцээ үржил шимт шинэ хар шороо нэмж жигд тараан тарих газрыг тармуураар тэгшлэх хэрэгтэй байдаг.



Гэрийн ногоон байгууламжийг зүлэгжүүлэх зорилгоор олон наст ургамлыг тариалсан тохиолдолд байнга усалж байх шаардлагатай бөгөөд хөрсний гадарга тэгш биш байвал ус тогтохгүй алдагдах болно. Зарим налуу газрын талбайг тариалалтад бэлтгэхдээ шатлан бэлтгэх арга байдаг. Зүлэг тарих талбайн хэмжээнээс хамаарч техникээр болон гар ажиллагаагаар хөрсийг боловсруулж, элсжүүлэн хөнгөн бүтэцтэй болгож, хар шороо нэмж бууцаар бордож талбайг засна. Тэгшилж бэлэн болсон талбайн нэг захаас 1м2 талбай бүрийг дахин хавтгай мод тавин дарж сул хөрсийг нягтруулан тэгшлээд 60-100 грамм үрийг жигд тараан цацаж дээрээс нь ХАШААНДАА САЙХАН АМЬДАРЬЯ.

Уулын хар шороо болон элсний холимгоор үрийг далд ортол /үр ил гарахгүй байхаар/ буюу 1-2 см зузаан цацаж дарна. Дараа нь тэгш хавтангаар сайтар дарж үрийг хөрсөнд суулгаж өгнө. Гэхдээ практик дээр м2 бүрийг хавтгай мод тавин дарах нь хэт их ажиллагаатай байдаг тул заавал тэгш шаардлагагүй юм. Энэ мэтээр 1м2 талбай бүрээр хөөн тарилгыг нягт нямбай хийсээр нийт талбайд хийж дуусгана. Үрээ суулгасны дараа бороожуулагч хошуутай усалгааны хоолойгоор /даралттай усаар/ жигд бороожуулж усална. Бүдүүн усалгааны хоолойгоор юм уу, хувингаар усалбал газар нь эвдэгдэж үр нь хуурай хөрснөөс ил гарах бөгөөд нэг удаа усанд сайн дэвтсэн үр буруу усалснаас болоод хөрснөөс ил гарвал хатаж дахин сэргэж ургах боломжгүй. Иймээс усалсны дараа ил гарсан үрийг дахин хөрсөөр дарж өгөх хэрэгтэй. Ингээд л тарьсан зүлэг тань 34 хоногт соёолж, 7-14 хоногт та ширдэг шиг ногоон зүлэгтэй болсон байх болно.

Та СӨХ-тойгоо хэрхэн хамтарч ажиллах вэ ?

СӨХ нь юу хийдэг ямар эрх үүрэгтэйг сайтар судалж мэдэн та тэдэнтэй хамтран ажилласнаар өөрсдийнхөө эрүүл, аюулгүй таатай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулж байгаа юм.

Зарим хотхон, орон сууцнууд эзэнгүй айл шиг хүүхдийн тоглоомын саад талбай нь эвдэрч муудсан, орц хонгил нь гэрэлгүй хогондоо дарагдсан, хаалга үүд нь эвдэрсэн эмх цэгцгүй амьдрахад таагүй мэдрэмжийг төрүүлж байдаг. Ийм газрууд ихэвчлэн СӨХ байхгүй, эсвэл СӨХ нь ажлаа хийдэггүй иргэд нь хамтарч нэгддэггүй, хороо нь эдгээрт хүрч ажиллаж чаддаггүй хэцүүхэн хэсгүүд байдаг гэж хэлж болох юм.

СӨХ нь Монгол улсын "Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн тухай эд хөрөнгийн тухай хууль болон "Сууц өмчлөгчдийн холбоодын захирлуудын албан хэрэгцээнд ашиглах баримт бичгийн гарын авлага" 2-г мөрдөж ажилладаг. СӨХ-г байгуулахдаа оршин суугчдын хурлыг хийнэ. Хуралд хорооны Засаг Дарга, дүүрэг хөгжлийн төвөөс хүмүүс байлцуулж бүх гишүүдийн хурлыг хийж ТУЗ болон хяналтын зөвлөлийн хүмүүсээ сонгоно. ТУЗ нь СӨХ-ны гүйцэтгэх захирлыг сонгодог.

Оршин суугч иргэдийнхээ өмч хөрөнгийн үнэ цэнийг алдагдуулахгүй, өнгө үзэмжтэй байлгаж, эрүүл аюулгүй таатай орчинд ая тухтай амьдруулахад л анхаарч байгаа бөгөөд орон сууцны байшингийн нийтийн эзэмшлийн талбайг эзэнтэй байлгадаг ганц байгууллага нь сууц өмчлөгчдийн холбоо (СӨХ) юм.

Зөвлөмж

Та СӨХ-ын үйл ажиллагааны тайлантай тогтмол танилцаж тэдний ажил үйлчилгээг сайжруулах, талархах, хяналт тавих зэргээр санал бодлоо илэрхийлж хамтран ажиллаарай.

Нийтийн орон сууцанд бусадтай хөрш болж болж амьдрахад таны оролцоо юу вэ?



Таны эрх бусдын эрхээр хязгаарлагдана гэдгийг ойлгож нийтээр дагаж мөрдөх журам, дүрмийг мөрдөн бусдад хүндрэл учруулахгүй, тэдний амар амгалан байдлыг алдагдуулахгүй амьдрахыг эрхэмлэх.



Хөршүүдийнхээ алдаа дутагдлыг зөвөөр ойлгуулж юу хүсээд байгаагаа тодорхой илэрхийлдэг байх.



Иргэдийн эрүүл мэнд, өмч хөрөнгийг хамгаалах үйл ажиллагаанд цагдаагийн байгууллага болон бусад хамтран ажиллагч байгууллагуудад туслалцаа үзүүлэн иргэний хувиас хамтран ажиллана.



Хөршүүдийнхээ зөв санал санаачлалыг дэмжин бусдыгаа уриалж идэвхтэй хамтран амьдрах.



Өөрсдийн амьдарч буй нутаг дэвсгэр болон орон сууцны эрүүл, аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх, ахуйн хүрээнд үйлдэгдэж буй гэмт хэргийн гаралтыг бууруулах зорилгоор иргэд, оршин суугчид сайн дурын үндсэн дээр нэгдэж хөршийн холбоог байгуулж болно.



Бусдын эрүүл мэнд, амьдрах орчинг бохирдуулалгүй, дүүрэг хороо СӨХ-ноос зохион байгуулсан ажилд идэвхтэй оролцож байх.

/Ж/нь Бүх нийтийн их цэвэрлэгээ/

Иргэн таны гэр бүлд хэрэгтэй мэдээлэл

Е Сууц өмчлөгчдийн холбоо (СӨХ) гэж юу вэ?

СӨХ гэж нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийг (орцны хаалга, дээвэр, цонх, халаах хэрэгслүүд, гэрэлтүүлэг, лифт. Нэмээд халуун, хүйтэн усны магистраль шугам сүлжээний тодорхой хэсгийн ашиглалт) дундаа хамтран өмчлөх, арчилж, цэвэрлэх, орон сууцны ашиглалтын хэвийн байдлыг хангах, сууц өмчлөгчдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, зорилго бүхий, хуулийн этгээдийн эрхгүй, заавал гишүүнчлэлтэй холбоог хэлдэг байна.

Нэг үгээр хэлбэл оршин суугаа иргэдийн аюулгүй, тухтай сайхан амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэн хангахын төлөө СӨХ байдаг байна.

Агаар

Агаарын бохирдлыг хамтдаа бууруулъя

Сайжруулсан шахмал түлш гэж юу вэ?

Сайжруулсан шахмал түлш гарган түүхий нүүрсний дэгдэмхий бодисыг /кокс болон хагас коксжуулсан/ угаах, нэрэх үйлдвэрийн аргаар агаарын бохирдлыг арилгаж /өндгөн гэх мэт хэлбэрт оруулсан, сайжруулсан хатуу түлшний техникийн болон бусад стандартын/ Техникийн шаардлага MNS 5679:2019/ шаардлагыг хангасан түлшийг хэлнэ.

Сайжруулсан түлшийг хэрэглэснээр агаарын бохирдол 50%-иар бууруулж байна.

Сайжруулсан шахмал түлшийг зөв хэрэглэх заавар



1	2	3	4
Алхам	Алхам	Алхам	Алхам
Шахмал түлшээ доор нь хийнэ.	Түлшнийхээ дээр модоо хийнэ.	Цуулсан мод зомгол хийнэ.	Шатах материалаа /цаас, үйс гэх мэт/ хийж асаана.


Сайжруулсан зууханд

Шахмал түлшээ доор нь хийгээд дээрээс нь модоо ноцгоож асаана. Түлш ноцсоны дараа зуухны халаалтыг тохируулж, хэрэглэгч өөрийн шаардлагад нийцүүлэн галлагааг хийнэ.

Уламжлалт зууханд

Цуулсан модон дээр 2-3 кг шахмал түлш хийж шатах материалаар асаана. Түлш шатаж эхэлснээс даруй хагас цагийн дараа галын хотлын 85%-ийс ихгүй байхаар дахин цэнэглэнэ. Түлшний хэмжээ буурах үед түлш унтрахаас өмнө дөлтэй үед дахин цэнэглэнэ.

Сайжруулсан түлш хадгалалт



- 1 Агааржуулалт сайтай, усанд норхоггүй, чийг авахгүй нөхцөлд, хадгалах
- 2 Хурдан шатах, тэсрэх дэлбэрэх /хий шингэн/ зүйлтэй ойр байлгаж болохгүй
- 3 Түлшний овоолго 1,5 м-ээс өндөргүй, өргөн нь 5 м-ээс илүүгүй байх шаардлагатай. Эс бөгөөс түлш өөрөө аяндаа шатах аюултай



Ахуйн зуухны ямар ямар төрлүүдийг ашиглах вэ?

Сайжруулсан шахмал түлшний хэрэглээг ахуйн хэрэглээнд нэвтрүүлснээр зөв галлагааны заавар зөвлөмжийн дагуу хэрэглэж сурах, зуухны цэвэрлэгээ, /хөө, үнс/ үйлчилгээг тогтмол хийх, гэрийн болон ханан пийшин хэрэглэж буй тохиолдолд битүүмж, утааны алдагдал зэргийг арилгах, арилгах шаардлагатай. Стандартын шаардлага хангасан Дулаан-2, ЗХТ-1, ЗХТ-2, Голомт, Жижиг, дел, Том дел, Чин-3 зэрэг зуухнуудыг өргөн хэрэглэж байна.

Хэрхэн зуухаа сонгох вэ?

Зуухны хувьд Монгол улсын MNS 5216:2016 Ахуйн хэрэглээний зуух, техникийн ерөнхий шаардлага хангасан, бүрэн шаталттай зуух хэрэглэж түүнд тохирсон сайжруулсан шахмал түлш хэрэглэнэ.

Цахилгаан халаагуурт хэрхэн шилжих вэ?

Цахилгаан халаагуурт шилжихийн тулд гэр хорооллын цахилгааны хүчин чадал, дэд бүтцийг нэмэгдүүлсний үндсэн дээр хэрэглээнд нэвтрүүлэх шаардлагатай. Цахилгааны монтаж шийдлийг оновчтой байршуулж галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн гүйцэд авч ажиллахыг анхаараарай.

Цахилгаан халаагуурын ямар шийдлүүд байдаг вэ?

Цахилгаан халаагуурын хувьд Стандартын/MNS6780 Дулаан хуримтлуурт цахилгаан халаагуур, Техникийн ерөнхий шаардлага./ шаардлага хангасан цахилгаан халаагуур хананы, шалны гэх мэт олон төрлүүдээс тухайн орон гэр, байр сууцанд тохируулан сонгон ашиглана.

Гэр, байшингаа хэрхэн дулаалах вэ?

Байшин, гэр сууцыг дулаалахдаа дулаан алдагдлыг тодорхойлсны үндсэн дээр дулаалгын материал сонгож хэрэглэх, холбогдох заавар зөвлөмжийн дагуу дулаалгаа хийгээрэй. Дулаалгын материал, байгальд ээлтэй техник, технологийн хөнгөлөлттэй зээлийг /ХАС, ХААН, ТӨРИЙН БАНК/ олгож байгаа тул тус банкаар дамжуулан дулаалгын болон байгальд ээлтэй технологи худалдан авах боломжтой юм.

Агаарын бохирдлыг бууруулахад оруулах таны хувь нэмэр

- 1 Хийн болон бусад түлшний хэрэглээг дэмжих
- 2 Гэр, байшиндаа дулаалга хийн дулаан алдагдлаа бууруулах
- 3 Ногоон байгууламжийг нэмэгдүүлж зүлэгжүүлэх (мод, бут, сөөг, зүлэг ногоо тарьж хөрсний элэгдлээс хамгаалах)
- 4 Цахилгаан халаагуур хэрэглэх
- 5 Зориулалтын бус байгууламж, гэрийн зууханд болон ил задгай хог хаягдлыг шатаахгүй байх
- 6 Шатахуун бага зарцуулдаг, зөв тохиргоотой автомашин хэрэглэх
- 7 Сайн чанарын түлш автомашиндаа хэрэглэх
- 8 Хосолмол хөдөлгүүрт болон хийн түлшээр явдаг автомашины хэрэглээг дэмжих
- 9 Нийтийн тээврийн үйлчилгээг түлхүү хэрэглэх
- 10 Олон жилийн насжилттай авто тээврийн хэрэгсэл аль болох ашиглахгүй байх (9 жилээс дээш)
- 11 Тансаг, том хүчтэй мотортой автомашин хот дотор унахаас татгалзах




G Хотын ногоон бүс

Хотын ногоон бүсээ хайрлаж хамгаалцгаая

Хотын аль хэсэг зуслан ногоон бүсэд хамаардаг вэ?

Нийслэл хотод нийт 26 ногоон бүсийн зуслангууд байдаг байна. Нийслэлийн хойд хэсгээр ихэвчлэн байрладаг.



Эх сурвалж линк: <https://www.arcgis.com/apps/webappviewer/index.html?id=47c22747196240b2af6def86ac5daea9>

Байгаль хамгаалагч гэж хэн бэ?

Байгаль хамгаалагч нь тусгай хамгаалалттай болон байгалийн дархан цаазат газрууд, уул уурхайн олборлолт, хайгуулын бүс, тэрчлэн хот суурин, хөдөө орон нутгийн байгаль орчныг хамгаалах, уул, ус, ой, амьтан, ургамал, түүний нөөц баялгийг зөв зохистой ашиглах, нөхөн сэргээхэд хяналт тавьж, түүнийг хэрэгжүүлэхэд туслах үүрэгтэй. Байгаль хамгаалагч нь өөрийн үйл ажиллагаандаа Монгол Улсын байгаль орчныг хамгаалах тухай багц хуулиуд болон Захиргааны хариуцлагын тухай хууль тогтоомжуудыг үндсэн удирдлага болгон ажилладаг хүн юм.

Зуслангийн товчоо

Нийслэлийн ногоон бүсийн зуслан бүхий амуудад оршин суугч иргэдийн эрүүл аюулгүй амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх, зуслангийн бүсийн хөрс, ус, орчны бохирдлыг бууруулах, нөхөн сэргээх, тохижуулах, иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх асуудлыг хариуцдаг газар юм.

Монгол Улсын Байгаль хамгаалах тухай багц хуулиуд тэдгээрт нийцүүлэн гаргасан холбогдох тогтоол шийдвэрийг нийслэлийн ногоон бүсэд хэрэгжүүлэх, зусланд ажил үйлчилгээ үзүүлж буй Төрийн болон аж ахуйн нэгж байгууллагуудын үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй байхаар зохион байгуулах, уялдаа холбоог сайжруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг хангах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх замаар зуслангийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, байгаль орчныг хамгаалахад тэдний оролцоог нэмэгдүүлэх, иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх, сургалт сурталчилгааг зохион байгуулан ажилладаг байна.

Үйл ажиллагаагаа зуслангийн бүсийн ой, усны сан бүхий газарт хууль бус газар олгосон зөрчлийг илрүүлж, хуулийн хэрэгжилтийг хангуулах, илэрсэн зөрчлийг арилгуулах, нийслэлийн нутаг дэвсгэрт мал аж ахуй эрхлэх журмын хэрэгжилтийг хангуулах, зуслангийн бүсэд экосистемийн үйлчилгээний төлбөр тооцох журам, урамшуулал олгох тогтолцоог нэвтрүүлэх боломжийг судлах, Эко бие засах газрыг байгуулах талаар төсөл боловсруулах, сурталчлах, "Зуслангийн зөвлөл"-ийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, зуслангийн бүсийн иргэдэд "what 3 words" буюу "3 үгт хаяг"-ийг сурталчлах, ашиглах, хэрэглээ болгох чиглэлээр явуулж байна.

Байгаль хамгаалагчийн хийх ажлын чиг үүрэг:

- 1 Орон нутагтаа байгаль орчныг хамгаалах чиглэлээр суртал ухуулга явуулах, иргэдэд байгаль орчноо хайрлах сэтгэл зүйг төлөвшүүлэх замаар хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах.
- 2 Байгаль орчинд учирч болзошгүй хор аюулаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, байгаль орчны ажиглалт судалгаа хийх, нөхөн сэргээлт, био-техникийн арга хэмжээг оновчтой зохион байгуулах.
- 3 Байгаль орчны тэнцвэрт байдал, унаган төрхийг хэвээр хадгалах, байгаль орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх, байгаль орчныг хамгаалах төсөл, хөтөлбөрүүдийг боловсруулах.
- 4 Байгууллагуудад хяналт тавих, заавар зөвлөгөө өгөх ажлыг тус тус гүйцэтгэх

Гурван үгт хаяг гэж юу вэ?

Монгол шуудан ХК нь илгээмж, шуудангийн хүргэлтийн үйлчилгээгээ илүү хурдан, шуурхай болгон сайжруулах зорилгоор Их Британи улсын what3words компанитай 2016 оноос эхлэн хамтран ажиллаж байна. What3words нь дэлхийн гадаргууг 3м*3м хэмтэй 57 их наяд квадратуудад хувааж, квадрат тус бүрийг дахин давтагдашгүй Гурван үгээр хаяглаж буй орчин үеийн хаягжилтын шинэлэг технологи юм.

Гурван үгт хаяжилт нь хэрэглэхэд уламжлалт байршил тодорхойлох аргатай харьцуулбал хамгийн хэрэглэхэд хялбар систем юм. Өөрөөр хэлбэл хүн бүр одоо хаана ч байсан Монгол гурван үгт хаягтай болсон гэсэн үг юм. Хаягийн мэдээлэл дээрээ гурван үгт хаягийг нэмэлтээр ашигласнаар үйлчилгээгээ түргэн авах боломжтой болохоос гадна бусадтай байршлаа төвөггүй хуваалцах боломжтой юм.

Та өөрийн гурван үгт хаягаа map.what3words.com болон what3words.com болон what3words үнэгүй апп ашиглан олж мэдэх боломжтой. Бид дэлхийн газрын гадаргын 3мх3м хэмжээтэй квадрат бүрт дахин давтагдашгүй гурван үгт хаяг хуваарилсан. Та гурван үгт хаяг нээж олох, хайх, хуваалцах, түүнчлэн чиглэл авахдаа what3words аппыг хэрэглэж болно. Байршил хайх буюу намайг ол гэсэн тэмдгийг дарж, торон сүлжээг харахын тулд газрын зургийг томруулж, квадрат бүрийн хувьд гурван үгт хаягийн өөрчлөлтийг харахын тулд зүүг хөдөлгө.

Тодорхой нэг гурван үгт хаягийг хуваалцах эсвэл түүн рүү хүрэх чиглэл авахын тулд үгийн хөндлийг товш. Эсвэл луужингийн горим дээр заагчийг даган чиглүүлж болно. Та энэ бүхнийг сүлжээгүй оффлайн горимд ч өөрийн сонгосон хэлээр хийх боломжтой. Оршин суудаг эсвэл ажилладаг газраа хүргүүлэхээр нарийвчилсан байршлаа хуваалцах; уулзалтын тохиромжтой цэгийг товлох; аяллын явцад олоход хүндрэлтэй газрыг нарийн заахдаа what3words-ийг ашиглаарай.

Гудамжны хаяг хангалттай нарийвчлалгүй эсвэл огт байхгүй үед энэ апп үнэхээр ач холбогдолтой юм

H Онцгой байдал

Болзошгүй аюулд бэлэн байцгаая

Гал түймрээс хэрхэн сэргийлэх вэ?

Гал түймрийн шалтгаан нөхцөл нь айл, өрхүүдэд ашиглагдаж байгаа пийшин, зуухны гэмтэл, хэт галлагаа, ил задгай асгасан цогтой үнс нурам, хараа хяналтгүй орхисон бага насны хүүхэд, иргэдийн болгоомжгүй үйл ажиллагаа, зориулалтын бус цахилгааны утасны ашиглалт, цахилгаан хэлхээний хэт ачаалал зэрэг хувь хүний санамсар болгоомжгүй байдлаас үүдэж байна.

Иргэн та өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлж:

Яндангийн цоолт, халалтаас хамгаалах

Пийшин, зуухны яндангийн хамгаалалтыг галд тэсвэртэй материалаар хийж яндангийн цоолт халалтаас хамгаалах. Яндангийн ил гарсан хэсгийн урт нь гэр, байшингийн дээврээс 60-80см-ээс дээш байх.

Үнс нурмаа ил задгай асгахгүй байх

Гал түймрийн шалтгааны 36.5 хувь нь ил задгай асгасан цогтой үнс нурамнаас үүдэн гарч буй учир халуун үнс, нурмаа тагтай үнсний саванд хийх хэвших.

Гэмтэлтэй цахилгаан хэрэгслийг ашиглахгүй байх

Бүрэн бүтэн байдал нь алдагдсан, шалбарсан, зарим хэсгээрээ халалт үүсэж хайлсан, залгуур унтраалга нь эвдэрсэн болон бусад гэмтэлтэй цахилгаан хэрэгслийг ашиглахгүй байх,

Гэр орондоо бензин болон бусад шатах, тослох материал хадгалахгүй байх

Хялбар гал гаргах асаагуур, чүдэнзийг хүүхдийн гар хүрэхээргүй газарт нууж тавих,

Хийн зуухны аюулгүй хэрэглээг хангах

Хийн зуухны буруу хэрэглээний улмаас гал түймэр гарах тохиолдол ихсэж байгаа учир хийн зуух ашиглах заавар, зөвлөмжийг дагах,

Гэр орондоо утаа мэдрэгч суурилуулж, гал унтраагуур байрлуулах

Утаа мэдрэгчийн хэвийн ажиллагаа болон гал унтраагуурын хадгалах хугацааг тогтмол шалгаж, гэр бүлийн гишүүдээ гал унтраагуурыг хэрхэн ашиглах талаар зааж сургах.

Дуудлага өгөх, бусдад мэдэгдэх

Гал гарсан тохиолдолд 101 утсанд яаралтай дуудлага өгөх. Өөрөө дуудлага өгөх боломжгүй бол хөрш айлуудаасаа тусламж хүс, чанга дуугаар хашхирч бусдад мэдэгдэх,

Галын машины замыг чөлөөлөх, мэдээллээр хангах

Галын машин ирэх замыг чөлөөлж, гал гарсан газарт очих замыг зааж өгөх. Галын голомт хаана байгааг тодорхой хэлж, гэр байшингийн дотор хүн үлдсэн эсэхийг яаралтай мэдэгдэх зэрэг арга хэмжээ авахыг анхааруулж байна.

Галны хорны Хэрэглээний төрөл



Нунтаг галын хор

Мод даавуу органик нэгдэл
Бензин шатамхай шингэн
Шатамхай хийнүүд
Цахилгаан хүчдэл



Хөөсөн галын хор

Мод даавуу органик нэгдэл
Бензин шатамхай шингэн
Цахилгаан хүчдэл болохгүй
Шатамхай хийнүүд болохгүй



Ус, усан галын хор

Мод даавуу органик нэгдэл
Цахилгаан хүчдэл болохгүй
Бензин шатамхай шингэн болохгүй
Шатамхай хийнүүд болохгүй



CO2 Хийн галын хор

Мод даавуу органик нэгдэл
Цахилгаан хүчдэл болохгүй
Бензин шатамхай шингэн болохгүй
Шатамхай хийнүүд болохгүй

Залгасан бол салга - Салгасан бол залга
Асаасан бол унтраа - Аюулгүй байдлыг баримтал

Ой хээрийн түймрээс хэрхэн сэргийлэх түүний санамж

1 Ахуйн дадлаас үүдэх эрсдэл



Цогтой үнс нурмаа битүү тагтай саванд хийх.

2 Хорт зуршлаас үүдэлтэй эрсдэл



Тамхи, чүдэнзний галыг ил задгай хаяхгүй байх.

3 Машин механизмаас үүдэлтэй эрсдэл



Хөдөө орон нутагт хуурай өвс ихтэй ой хээрийн бүс малын бэлчээрт явахдаа оч баригчгүй машин техникээр зорчихгүй байх.

4 Ахуйн байдлаас үүдэх эрсдэл



Гэр сууц, хашаа хорооны гадуур түймрээс хамгаалах зурвас татах

5 Ахуйн байдлаас үүдэх эрсдэл



Шаардлагатай багаж хэрэгслийг бэлдэх зэрэг нь өөрийгөө болон бусдын амь нас эрүүл мэнд, эд хөрөнгийг ой, хээрийн түймэрт өртөхөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрүүл аюулгүй орчинд амьдрах баталгаа болохыг анхааруулж байна.



ОЙ ХЭЭРИЙН ТҮЙМЭРИЙГ МЭДЭЭЛЭХ ДАРААХ ДУГААРЫГ ЦЭЭЖЛЭЭД АВААРАЙ.

ИРГЭН ТА:

Ой хээрийн түймэр гарсан тохиолдолд Онцгой байдлын алба болон орон нутгийн төрийн захиргааны байгууллагад яаралтай мэдээлэх түймэр унтраах ажиллагаанд иргэний үүргийн дагуу оролцох үүрэгтэй.

Газар хөдлөлт ба хариу арга хэмжээ

Газар хөдлөлт гэж юу вэ?

Газар доор болон гадарга дээр их хэмжээний чичирхийлэлт болж, хүчтэй үйлчлэлийн улмаас газрын гадаргад ан цав бий болохыг газар хөдлөлт гэдэг.

Газар хөдлөлтийн шинж тэмдгүүд	Байшин донслон хөдлөх	Чийдэнгийн бүрхүүл болон өлгөөтэй эд зүйлс савах	Шилэн сав суулга харших, дуугарах, хагарч буй шилний чимээ гарах	Хүнгэнэсэн дуу ойртох
--------------------------------	-----------------------	--	--	-----------------------

Хэрвээ ийм шинж тэмдэг мэдрэгдвэл нэн түрүүнд байшин барилгыг яаралтай орхих, хүмүүсийг гадагш хурдан гаргах эсвэл тасалгааны аюулгүй байрыг эзлэх хэрэгтэй.

Газар хөдлөлтийн үед юу хийх вэ?

Газар хөдлөх үед байшин дотор байгаа бол

Тайван бай, үймж сандрах хэрэггүй Аюулгүй газар хорогдох /нуугдах/ дотор хана, булан, даацын багана гэх мэт.

Газар хөдлөлт эхлэх үед Та хаана байна, тэндээ л газар сууж, өөрийгөө халхлах, хүлээх

Бат бөх ширээн доогуур орох

Цонхноос хол байх

Цаг, таазны гэрэл зэрэг дээрээс унах зүйлсийн доор зогсохгүй байх

Хаалга онгойлгоод доор нь зогсвол дээрээс унасан зүйл цохих аюул харьцангуй бага

Урьдчилан базаах бэлтгэл:

Хэрвээ газар хөдлөлт танай гэр орон, сургууль, ажлын байранд юу юу гэмтэж магадгүй талаар ярилцах

Өрх бүр гамшгийн үед ажиллах төлөвлөгөөтэй байх

Өрөө, тасалгаандаа хамгийн аюулгүй хэсэг нь хаана байж болохыг урьдчилан тогтоох. Ер нь хамгийн аюул багатай хэсэг бол коридор (хэрвээ энд тавилга, эд зүйлс ихээр байрлуулаагүй бол) гэж үздэг.

Аюулгүй газар руу орох /нуугдах/, халхлах, байх зэргээр дадлага, сургуулилт хийх

Аюулын үед барилга, байшингаас гарах гарц, аюулын гарцыг мэддэг байх

Өндөр настай хүмүүс, нялх балчир хүүхдүүдийг хэрхэн нүүлгэн шилжүүлэхийг урьдаас тооцох

Газар хөдлөх үед гадаа байгаа бол

Байшин, барилга, мод, гэрэл болон цахилгааны шонгоос хол, аюулгүй газар олох

Хэрвээ машин дотор байгаа бол чичирхийлэлт зогсол машинаасаа гарах хэрэггүй

Машинаар явж байгаа бол замаас гарч зогсох, гүүр, тунелээс холдох, ил задгай талбай олох

Олон нийтийн газар байвал хаалга, үүд рүү хамаагүй бүү зүтгэ. Дээрээс унаж болзошгүй зүйлээс холдохыг хичээх

Театр, цэнгэлдэх хүрээлэнд байсан бол суудалдаа суугаад толгойгоо хамгаалах

Ойр орчимд тэсэрч, дэлбэрэх бодис байгаа бол лаа асаах юм уу, гал гаргаж болохгүй

Хэрэв уулархаг газар амьдардаг бол хад чулуу нурж унахаас болгоомжлох

Гэр бүлийн гишүүд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх чадварыг эзэмших

Ус, цахилгаанаа яаж, хаагуур нь хааж, унтраахад суралцах

Гэр, өрөө, тасалгааныхаа овор ихтэй, хүнд тавилгыг зохих ёсоор бэхлэх, тогтоох

Дор хаяж 72 цагийн хүнс, усны нөөцтэй байх
Цонх, гадна хананаас ор, буйдан зэргийг хол байрлуулах

Аюултай болон химийн хортой бодисыг зориулалтын газар тусгаарлан хадгалах

Гар чийдэн (нэмэлт зайны хамт), зайгаар ажилладаг жижиг радио, эмийн сан гэх мэт зүйлсийг бэлтгэх

Газар хөдлөлтийн дараа юу хийх вэ?

Өөрийн сэтгэл санааг бүрэн эзэмдэж, эрүүл ухаанаар эргэн тойрноо харах

Эхлээд өөрийгөө бэртсэн эсэхийг шалгах

Хэрвээ цус алдаж байвал цэвэрхэн материал ашиглан цус тогтоох арга хэмжээ авах

Хүнд гэмтэлтэй хүнийг хамаагүй хөдөлгөж, тээвэрлэж болохгүй

Эмнэлгийн анхны тусламж үзүүлэх

Хүүхэд, өндөр настан, өвчтэй хүмүүсийг тайвшруулах

Нурангид дарагдсан хүмүүсийг өөрийн бололцооны хэрээр аврах

Онцгой чухал шаардлагагүй бол байшинд орох хэрэггүй

Нурангин доор байгаа бол тайван байх, боломжтой бол өөртөө анхны тусламж үзүүлэх

Гадна байгаа хүмүүст дохио өгөх /хашхирах, ямар нэгэн юм нүдэх/

Гал гаргаж болохгүй

Өөрийн тамир, тэнхээгээ гамнах

Шилний хагархай байх тул гутлаа өмсөх

Ямар нэг эвгүй үнэр байвал цонх, салхивчаа нээх

Цахилгаанаа яаран бүү залга

Радиоогоо цаг үеийн мэдээн дээр тохируулах

Гэрийн тэжээвэр мал, амьтныг халхлах аюулгүй байршил, газрын тогтоох

Хүн бүрийн орны дэргэд гар чийдэн, бат бөх гутал байлгах

Нэн шаардлагатай байгууллагын утасны жагсаалтыг мэддэг байх

Угаарын хийн хордлогоос сэргийлэх

Угаарын хий гэж юу вэ?

Ямарваа зүйл шатахад утаа болон CO2 ялгардаг. Утаа нь тортог, нунтаг тоосонцор холилдсон багсарсан хар зүйл бөгөөд түлш агаар дахь хүчилтөрөгчтэй урвалд орж шатахад ялгардаг хий юм. Хоргүй хий ба бидний уудаг ундааны газ гэсэн зүйл юм. Гэтэл зууханд дотор агаарын эргэлт муутай, хүчилтөрөгч хангалттай биш байвал CO2-ын оронд CO үүснэ. Энэ бол угаарын хий бөгөөд өнгө, үнэр байхгүй үхлийн аюултай хорт хий юм.

Галлагааны үед угаарын хий үүсэх магадлал ихсэх ба энэ нь нүүрсийг шатааж эхлэх үед болон шаталт дуусаж гал бөхөх үед угаарын хий хамгийн ихээр ялгардаг. Тэр үед яндангийн таталт сайн байх хэрэгтэй гэсэн үг. Яндангийн таталт сайн байх юм бол гадаад орчиндоо цацагдаад сарнидаг. Гэтэл таталт муу байвал зуухны амаар гэр дотроо ялгараад аминд хүрэх эрсдэлийг бий болгодог.

Хэрхэн сэргийлж болох вэ?

Нэгдүгээрт
зуухны агаарын эргэлт сайн байх хэрэгтэй байх нь.

Хоёрдугаарт
Яндангийн таталт сайн байх хэрэгтэй байх нь.

Гэхдээ зуухны хэлбэр хийц, дизайн элдэв юм ярьж толгой эргүүлэхээ болиод хэрэглээнд анхаарах зүйлийг хэлье.

1-рт шөнө унтахынхаа өмнө зуухны бүхээгний хаалтыг битгий багасга! Манайхан дулаанаа барих гээд багасгаж нээдэг. Багасгамаар байгаа бол өдөр, орой хүмүүс байхад тодорхой хэмжээгээр багасга. Хэзээ ч битгий тултал нь хаа. Хамгийн гол нь унтахынхаа өмнө битгий багасгаж бай.

2-рт зуухаа дүүртэл нүүрс битгий хийж бай. Яндангийн хоолой дээр нүүрс овоорох, эсвэл үнслэг ихтэй бол үнс овоороод таталт нь буураад угаарын хий гэр дотор ялгарах эрсдэлийг нэмэгдүүлдэг.

3-рт аль болох өмнөх нүүрс шатаж дуусаагүй илчтэй, халуун байхад нь дээрээс нь шинэ нүүрсээ бага багаар хий. Ингэснээр утаа бага ялгарна. Угаарын хий ч багаар ялгарна.

Зөвлөмж

Агаарын температур дулаарч байгаа үед иргэд та бүхэн угаарын хийнээс урьдчилан сэргийлнэ үү. Агаарын температур хүйтрэх тусам зуухны таталт сайжирч, дулаарах үед зуухны таталт мууддаг тул угаарын хий үүсэхээс урьдчилан сэргийлж дараах зүйлд анхаарна уу!!!

- 1 Бага насны хүүхдийг хараа хяналтгүй орхихгүй байх
- 2 Бүрэн шаталттай сайжруулсан зуух хэрэглэх
- 3 Зуух пийшин яндангийн бүрэн бүтэн байдлыг хангах, зуух, пийшингийн амыг онгорхой орхихгүй байх
- 4 Янданг тогтмол хөөлөх
- 5 Гражид машин халаахдаа гражийн хаалгыг хаахгүй байх
- 6 Гэр байшингийн агаар сэлгэлт зэргийг тогтмол шалгаж анхаарна уу

Гэр байшиндаа агааржуулалат хийцгээе.

-  Ассан цогон дээрээ гал нэмэхдээ Заавал модоор асааж байж түлшээ нэмээрэй
-  Уугиулж болохгүй Угаарын аюултай
-  Галаа ассан эсэхийг дахин шалгаарай
-  Унтахаасаа өмнө гэр байшингаа агааржуулаарай
-  Нунтаг түлш хэрэглэж болохгүй

Эцэг эхчүүдийн анхааралд

- 1 Та хүүхдээ гэрт үлдээх үедээ шахмал зуухаа шахмал түлшээр хэт дүүргэхгүй байх
- 2 Шахмал түлшийг бүрэн шатаагүй байхад яндангийн хаалтыг авахгүй байх
- 3 Зуух яндангийн бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгах
- 4 Угаарын хий мэдрэгч дохиоллыг гэр сууцандаа байршуулах
- 5 Янданг тогтмол хөөлж үнсний савыг цэвэрлэх
- 6 Галлагаа хийхдээ нунтаг түлш хэрэглэхгүй байх

Угаарын хийн хордлогын шинж тэмдэг

Карбонмоноксид

/угаарын хий/-ийн хордлогын шинж тэмдэг нь ханиадтай төстэй бөгөөд толгой эргэх, дотор муухайрах, бөөлжих, хоолны дуршилгүй болох шинж тэмдэг илэрнэ. Мөн нярай жирэмсэн эмэгтэйчүүд, өндөр настнууд, зүрх амьсгалын замын өвчтэй хүмүүст түлхүү илэрнэ. Хэрэв Карбонмоноксид /угаарын хий/-ийн хордлогын шинж тэмдэг илэрвэл яаралтай эмчид хандах хэрэгтэй. CO-ийн хордлогын карбоксигемоглобины шинжилгээгээр тодорхойлж болно.

Угаарын хийн хордлогын үед та яах вэ?

- ✓ Угаартай орчноос агаарт гаргах
- ✓ Толгой, биеийг хүчиж ороон агаарт гаргах, халуун, бүлээн шингэн зүйл уулгах
- ✓ Ам, хамар, залгиурыг чөлөөлж, цэвэрлэх
- ✓ Тэгш гадаргуу дээр хэвтүүлж эрүүг өргөн амьсгалын замыг чөлөөлж хэл унахаас сэргийлэх, хуруу эсвэл савханд ороосон самбайгаар ам, залгиурыг цэвэрлэх
- ✓ Унтуулахгүй байх
- ✓ Спирт үнэртүүлэх, нүүрийг хүйтэн усаар шавших зэрэг Эмчид яаралтай хандах
- ✓ Шаардлагатай үед хиймэл амьсгал, цээж шахалтыг яаралтай хийх

Мөн та өрөө бүртээ Угаарын хий мэдрэгчийг байршуулаарай.

Угаарын хий мэдрэгчийг унтлагын өрөө, зочны өрөө, коридор, шатны төгсгөл, подвал зэрэг олон давхар байшингийн давхар бүрт дохиоллыг суурилуулахыг зөвлөж байна.



Угаарын хийн мэдрэгчийг зөв байршуулах зураг

Угаарын хий мэдрэгчийг байршуулахдаа

- 1 Дохиоллыг зуухны ойролцоо буюу дээр байрлуулж болохгүй
- 2 Нойтон чийгтэй газар байрлуулж болохгүй
- 3 Утаа мэдрэгчийг будах эсвэл шингэн зүйлд хүргэхээс сэргийлээрэй

Иргэн та Сервис төвийн 7011-9400 утсаар дуудлага өгч зуухаа үнэгүй засуулж заавар зөвлөгөө авах боломжтой

Үер усны аюулаас сэргийлэх

Үер гэж юу вэ?

Аадар бороо эсвэл удаан хугацаанд үргэлжилсэн зүс бороо, хайлсан цас, мөсний усны нөлөөгөөр усны төвшин эрс нэмэгдэх, газар хөдлөлт, хөрсний гулсалт, мөсөн хахаа, мөстлийн хайлалт зэрэг байгалийн үзэгдлээр нуур, усан сан задрах, далан нурах зэрэг бусад техникийн гаралтай гамшгаас ус эргээсээ халих, татам болон эрэг орчмын газар усанд автахыг ҮЕР гэнэ. (MNS 2009)

- 1 Цаг агаарын огцом дулаарлын нөлөөгөөр хайлсан цас, мөс, уулын бэл, жалга судаг, хоолой хөндийгөөр ус урсах, усанд автах, голын ус эргээсээ халих, татам болон голын эрэг орчмын газар усанд автахыг ШАР УСНЫ ҮЕР гэнэ. (MNS 2009)
- 2 Хур бороо, хайлсан цас, мөсний устай гадаргын сэвсгэр хурдас, чулуулаг холилдон газрын хэвгий даган урсах хүчтэй хуйлраа урсгалыг УРУЙН ҮЕР гэнэ. (MNS 2009)
- 3 Эрчимшил ихтэй аадар болон зүс борооноос голын усны төвшин богино хугацаанд нэмэгдэн ус эргээ хальж татам болон эрэг орчмын газар усанд автахыг ХҮР БОРООНЫ ҮЕР гэнэ. (MNS 2009)
- 4 Үерийн үндсэн сүйтгэгч хүчин зүйл нь асар их хэмжээний усны ширүүн урсгал, өндөр давалгаа, усны эргүүлэг, их хэмжээний хүйтэн ус, усанд хөвөх янз бүрийн хүнд зүйлс юм.
- 5 Үерийн усны хурд нь 4 м/сек-ээс дээш ба өндрийн төвшин нь 2м-т хүрэхэд хүн, амьтны амт насанд аюул учруулдаг байна. Барилга, байгууламж нь үерийн усны хүчтэй давалгаа болон уерт хөвж байгаа хүнд зүйлсийн цохилтод эвдэрч сүйдэг байна.
- 6 Үерийн үед салхи, хүйтрэлт, цахилгаан гүйдэл, усанд байх янз бүрийн халдварт өвчин үүсгэгч бичил биетүүд нь түүний сөрөг нөлөөг нэмэгдүүлдэг.

Хэрвээ танайх үерийн усанд автахар бүсэд байгаа бол дараах арга хэмжээг авч хэрэгжүүлээрэй

- ✓ Онцгой байдлын албанаас өгөх мэдээллийг анхааралтай сонсох, өгсөн үүрэг даалгаврыг нь биелүүлэх.
- ✓ Хий, ус, цахилгаан дамжуулах сувгуудаа хаах. Гал, цахилгаан хэрэгслээ унтраах.
- ✓ Үнэтэй эд зүйл, гэрийн тавилгаа дээд давхар эсвэл дээврийн хэсэгтээ гаргах.
- ✓ Цонх хаалгаа хаах эсвэл даруулж хадах.
- ✓ Амьтдыг хашаанаас нь гаргах, нохойгоо уяанаас нь тавих.
- ✓ Түлээ мэт зарим амархан урсах зүйлсийг байр саванд оруулах.
- ✓ Хонгил дахь эд зүйлсийг усанд автаж муудахаас сэргийлж гаргах.
- ✓ Нүүлгэн шилжүүлэхэд бэлэн байх.

66

Хүлээ, бүү гатал, өндөрлөг газарт оч нөхцөл байдлыг үнэл

Үерийн усны түвшин хурдан нэмэгдэж байвал

- ✓ Гэрт байгаа хоол хүнсээ хамгаалах хэрэгтэй бөгөөд нүүлгэн шилжүүлэх ажиллагаанд бэлтгэх.
- ✓ Завь, хоосон торх, гуалин мод, дүнз, дугуйны хаймар зэрэг хөвөгч хэрэгсэл болгон ашиглаж болохуйц эд зүйлсийг бэлдэх.
- ✓ Аврах ажиллагаанд ашиглах хийлдэг гудас, хуванцар сав зэргийг бэлдэх.
- ✓ Тусламж иртэл байшингийн дээд давхар, дээвэр дээрээ болон дээврийн хөндийд мөн өндөрлөг газарт гарах.
- ✓ Туг, бамбар, дэнлүү болон чийдэнгийн гэрлийн тусламжтайгаар аврагчийн өгч буй зааврыг дагаж ажиллах.
- ✓ Усанд автсан газарт аврах ажиллагаа ирэх боломжгүй болсон тохиолдолд аврах ажиллагааг өөрөө бие даан хийх.
- ✓ Усны урсгалын хурд, чиглэл зэргийг анхааралтай ажиглаж тайван, бүх зүйлийг нарийн зохион байгуулалттай хийх.

Үерийн усны түвшин хурдан нэмэгдэж байвал

- ✓ Гэрт байгаа хоол хүнсээ хамгаалах хэрэгтэй бөгөөд нүүлгэн шилжүүлэх ажиллагаанд бэлтгэх.
- ✓ Завь, хоосон торх, гуалин мод, дүнз, дугуйны хаймар зэрэг хөвөгч хэрэгсэл болгон ашиглаж болохуйц эд зүйлсийг бэлдэх.
- ✓ Аврах ажиллагаанд ашиглах хийлдэг гудас, хуванцар сав зэргийг бэлдэх.
- ✓ Тусламж иртэл байшингийн дээд давхар, дээвэр дээрээ болон дээврийн хөндийд мөн өндөрлөг газарт гарах.
- ✓ Туг, бамбар, дэнлүү болон чийдэнгийн гэрлийн тусламжтайгаар аврагчийн өгч буй зааврыг дагаж ажиллах.
- ✓ Усанд автсан газарт аврах ажиллагаа ирэх боломжгүй болсон тохиолдолд аврах ажиллагааг өөрөө бие даан хийх.
- ✓ Усны урсгалын хурд, чиглэл зэргийг анхааралтай ажиглаж тайван, бүх зүйлийг нарийн зохион байгуулалттай хийх.

Үерийн усанд унасан тохиолдолд

Айж сандралгүй тайван байж бүх хүчээ дайчлан усны эрэг, барилга, байгууламж, хөвөгч эд зүйлд хүрэх.

Усны гадаргуу дээр хөвөгч эд зүйлсийг ашиглан хөвөх.

Хүчээ зөв зарцуулан сэлж эрэг рүү дөхөх.

Ус залгихаас зайлсхийх.

Аврах ажиллагааны үед сэлэх шаардлага гарвал аль болох хөвөх хэрэгсэл юмуу, уяа татлагатай байх.

Гутал, хүнд хувцсаа тайлж эрэг ба ойролцоох барилга, байгууламж юмуу хуурай газар руу сэлж тэндээ аврагчийг иртэл хүлээх.

Үерийн усанд өртөж живсэн хүнд анхны тусламж үзүүлэхдээ

Аварсан хүн ухаан алдаагүй байгаа тохиолдолд түүнийг хэвтүүлж, халуун бүлээн зүйл уулгаж сайн дулаацуулж сэтгэл санааг нь тайвшруулах.

Ухаан алдсан бол нэн даруй түүний амьсгалыг нь сэргээх. Үүнийг маш богино хугацаанд буюу 10-15 секундэд багтаан амьсгалын замыг нь усгүй болгож дээш харуулан хэвтүүлж хиймэл амьсгал эсвэл зүрхэнд нь иллэг хийх.

Яаралтай түргэн тусламж дуудах.

Шаардлагатай тохиолдолд нэн даруй эмнэлгийн байгууллагад хүргэх, тээвэрлэх үед хамгийн тохиромжтой байрлал болох хажуугаар нь хэвтүүлнэ.

Үер болсны дараа юу хийх вэ?

Үер болж өнгөрсний дараа дахин ус үерлэхээргүй бол гэртээ эргэн ирж сэргээн босгох ажлыг хийх.

Хамгийн түрүүнд аюулгүй байдлыг хангах хэрэгтэй. Байшин дотор хана, тааз зэрэг зүйлс нурж аюултай болсон байж болзошгүй тул маш болгоомжтой орох.

Орон сууцанд хий алдагдсан байж болох тул ил гал гаргаж болохгүй.

Байшингийн дотор тал тавилга, хэрэгслээ сайтар хатааж цэвэрлэх.

Хашаа хороогоо сэргээж барих, ус их орж ирсэн хэсгээр хамгаалалт хийх, үерийн суваг шуудуу үүсгэж усны урсгалын чиглэлийг өөрчлөх.



Та аюул ослоос гэр бүлээ хэрхэн хамгаалах вэ?

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ

- ✓ Цаг агаарын урьдчилан сэргийлэх болон онц аюултай үзэгдлээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, мэдээ, дохиог хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн бусад эх сурвалжаас тогтмол хүлээн авч, бусдад дамжуулах, айл хотлоороо хамтран бэлэн байдлыг хангах.
- ✓ Тэнгэрийн байдал, үү, салхины чиг, мал амьтны хөдөлгөөн, араншинг шинжих гэх тэм цаг агаарыг таньж мэдэх ардын уламжлалт арга ухаанаас хүүхэд залуучуудад өвлүүлэх.
- ✓ Аюулт үзэгдлийн үед өөрийн болон бусдын эрүүл мэнд, амь насыг хамгаалах, аврах, анхан шатны тусламж үзүүлэх мэдлэг, дадлагатай болох.
- ✓ Хоол хүнс, ундны ус, түлш, анхны тусламж үзүүлэхэд шаардлагатай эм тариа, ариун цэврийн хэрэгслэл, дулаан хувцас бэлтгэх, гэр мэтийн хөнгөн сууцыг хүнд зүйлээр даруулах.
- ✓ Гар утас, радио, телевиз, гэрэлтүүлэх хэрэгслийг цэнэглэх, бэлэн байлгах.
- ✓ Иргэний чухал бичиг баримт, үнэт зүйлсээ хийсэхээс хамгаалсан найдвартай газар хадгалах, түүнийг гэр бүлийн гишүүд мэддэг байх.
- ✓ Хүүхэд, жирэмсэн эх, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хараа хяналтандаа байлгах, аюулгүй байдлыг нь хангах.
- ✓ Өвс тэжээлийн нөөцтэй байх, хашаа саравчаа дулаалах, худаг усыг хамгаалах, нөмөр нөөлөг газруудыг тогтоох, түүнийг хүн бүх мэддэг байх.
- ✓ Мал сүргээ хамгаалах арга хэмжээ авсан байх.
- ✓ Амь насны болон гэнэтийн ослын даатгалд хамрагдах.
- ✓ Өндөр хүчдэл, цахилгааны шугаман дор гэр, сууцаа барихгүй байх.
- ✓ Гэр бүлийн орчинд болон бусад газарт учирч болох эрсдэлийг урьдчилан тооцролж хариу арга хэмжээ авах ур чадварт суралцсан байх.

I Эрүүл мэнд

Өрхийн гишүүн бүрээ эрүүл байлгацгаая

Өрхийн эмнэлэгтэй хэрхэн холбогдох вэ?

Өрхийн эрүүл мэндийн төв нь харьяа хороонд оршин суугч болон бүртгэлгүй иргэдэд үйлчилдэг. Өрхийн эрүүл мэндийн төвийн мэдээлэл, байршлыг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын www.ubhealth.mn цахим сайтаас болон 11-325054 дугаарын утсаар авахаас гадна Өрхийн эрүүл мэндийн төв нь цагдаагийн хэсэг хороотойгоо хамт нэг цогцолбор байранд байрладаг.



Ахуйн осол гэмтлийн үед гэр бүлдээ болон өөртөө анхны тусламжийг хэрхэн үзүүлэх вэ?

Таны хайхрамжгүй орхисон нэг хором таныг болон таныг хүүхдийг насан туршийн эрсдэлд оруулдаг.

Бага насны хүүхэд түлэгдсэн бол дараах арга хэмжээг авна.

- ✓ Түлэгдсэн эх үүсвэрийг биеэс салгах
- ✓ Түлэгдсэн хэсгийн хувцас эд зүйлсийг болгоомжтой тайлах (хайчлах)
- ✓ Түлэгдсэн хэсгийг 10-15 минут тасалгааны хэмтэй урсгал усаар хөргөх
- ✓ Түлэгдсэн хэсэгт ариун боолт хийх (шарханд хүргэж наалдуулахгүйгээр)
- ✓ Цэврүү үүссэн бол хэрхэвч хагалж болохгүй (халдвар орно)
- ✓ Түлэгдлийн талбай, түлэгдлийн зэргээс үл хамааран эмчид заавал үзүүлэх
- ✓ Дур мэдэн барааны саван, элсэн чихэр амьтны цус гэх мэт элдэв янзын тос түрхэж болохгүй

Өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ гэж юу вэ?

Эрүүл мэндийн тухай хуулийн хоёрдугаар бүлгийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэгт заасанчлан “Өрхийн анагаах ухаанаар мэргэшсэн эмнэлгийн мэргэжилтний анхан шатны тусламж, үйлчилгээг бие дааж, эсхүл багаар үзүүлэх өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ”-г хэлнэ.

Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг Өрхийн эрүүл мэндийн төвөөс авна.

Тухайлбал: Эмчийн үзлэг, хяналт, өдрийн эмчилгээ, эрт илрүүлэг, бага насны хүүхдийн дархлаажуулалт, жирэмсэн эмэгтэйчүүдийн хяналт, төрсний дараах хяналт, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа гэх мэт.

Амьдрах орчныг аюулгүй болгох

- ✓ Гэрийн тавилгыг шатамхай бус материалаар хийх
- ✓ Монгол гэрийг шатамхай бус материалаар доторлох
- ✓ Чанартай залгавар уртасгагч хэрэглэх
- ✓ Гал зуухны хэсгийг тусгаарлаж хаалт байрлуулах,
- ✓ Халуун савтай хоол шингэнг гал зуухны хэсэгт аягалах, байршуулах
- ✓ Чүдэнз асаагуур, цэвэрлэгээний бодис, уксус, эмийг хүүхдийн гар хүрэхгүй газар тавих
- ✓ 5-аас дээш настай хүүхэдтэй айл хэрэв халуун тогоог хэрэглэх бол хамгаалалтын суурин дээр байрлуулах
- ✓ Галд шатдаггүй дэвсгэр хэрэглэх
- ✓ Галын хор, галд тэсвэртэй нөмрөг гал унтраах, гал унтраах чадвар эзэмших
- ✓ Тээглэж унахаас сэргийлж шалан дээрх хивс, урт залгаврыг ил орооцолдуулан ашиглахгүй байх

Анхны тусламж хэрэгтэй үед хамгийн түрүүнд хэнд хандах вэ?

Нийслэлийн Түргэн тусламжийн төв **103** дугаарын утас руу залгаж тусламж хүснэ.

Эмийн зохистой хэрэглээ гэж юу вэ?

Эрүүл мэндийг эмчлэх оношлох болон түүнээс урьдчилан сэргийлэх зориулалттай, эмчилгээний үр нөлөө нь судалгаагаар нотлогдсон орчин үеийн эмийн хэлбэрт оруулан тодорхой тун хэмжээгээр савласан бэлдмэлийг эм гэнэ.

Эмийн зохистой хэрэглээ гэдэг нь эмийг өвчин болон хувь хүний онцлогт тохируулан сонгож, тун хэмжээ, хэрэглэх арга болон эмийн хэлбэрийг оновчтой сонгох, сонгосон эмээ эмчийн зааврын дагуу зөв зохистой хэрэглэхийг эмийн зохистой хэрэглээ гэнэ.

COVID-19 КОРОНАВИРУСИЙН ХАЛДВАРААС СЭРГИЙЛЬЕ!

Хэрэглэсэн маскаа хэрхэн зөв хаях вэ?



1. Маскаа тайлаад



2. Дотор талруу нь таллаж нугалаад



3. Маскны резинээр боох



4. Цаасан болон гялгар уутанд хийгээд



5. Хогын саванд хаяна



6. Хогоо хаясны дараа заавал гараа угаагаарай

Ахуйгаас гарах эмнэлгийн хог хаягдлын хор нөлөө

Эмнэлгийн хог хаягдал нь оношлогоо, эмчилгээ, дархлаажуулалт болон судалгаа шинжилгээний үйл ажиллагааны явцад үүсдэг. Эмнэлгийн хог хаягдалд хурц үзүүртэй иртэй зүйлс, хэрэглэсэн зүү, тариур, хүний биеийн шингэн түүгээр бохирдсон зүйлс, нэг удаагийн хэрэглэл, ороох боох материал, өсгөвөр, эдийг сорьцын үлдэгдэл, хэрэглэсэн эм, химийн бодисын хог хаягдал, цусны наалдац бэлтгэсэн тавиур шил, даралтад сав, анатомийн хог хаягдал, эхэс зэрэг зүйл хамаардаг.

Эмнэлгийн хог хаягдал бүх хүнд нөлөөлнө. Таны зөв дадал, зөв хандлага таныг хог хаягдлын эрсдэлээс хамгаална.

Ахуйн нөхцөлд эмнэлгийн гаралтай хог хаягдсан тохиолдол ихээр гардаг учраас иргэдэд хог хаягдлыг ангилан ялгах, аюулгүй хайрцаг хэрэглэх дадалд сургах нь хамгийн чухал юм. Мөн ахуйн хог хаягдалтай хамт хаягдсан эмнэлгийн гаралтай хог хаягдлыг ангилан ялгах ажилтныг хурц иртэй, үзүүртэй хог хаягдалд хатгуулахаас сэргийлж хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах нь хамгийн чухал юм.

Халдварт өвчний үед ашигласан маск, бээлийн зэрэг зүйлсээ тусгайлан уутанд хийж битүүмжилсний дараа хаяж хэвшээрэй.



Г Гэмт хэрэг зөрчил

Гэмт хэрэг зөрчлөөс хамтдаа сэргийлье

Гэр бүлийн хүчирхийлэл гэж юу вэ

Гэр бүлийн хүчирхийлэл нь олон хэлбэрээр үйлдэгддэг бөгөөд дараах хэлбэрүүдээр үйлддэг байна.

1 Бие махбодын хэлбэр

гэдгийг гэр бүлийн гишүүн, нөгөө гишүүдийг өөрийн эрхшээлд байлгах, гэр бүлийн харилцаанд давамгайл байдал тогтоох зорилгоор хүч хэрэглэн биед нь халдсаныг ойлгоно.

2 Сэтгэл санааны хэлбэр

гэдгийг гэр бүлийн гишүүн, нөгөө гишүүдийг өөрийн эрхшээлд байлгах зорилгоор нөгөө этгээдийнхээ айлган сүрдүүлэх, заналхийлэх, мөрдөн мөшгөх, доромжлох, нэр төр алдар хүндийг гутаах, ах дүү, хамт олноос нь тусгаарлах, хүсэл зоригийнх нь эсрэг үйлдэл хийлгэхийг албадах, тулган шаардах зэргээр үг яриа, үйл хөдлөлөөрөө сэтгэл санааны дарамтад оруулсныг ойлгоно.

3 Бэлгийн хэлбэр

гэдгийг гэр бүлийн гишүүн, нөгөө гишүүдийг өөрийн эрхшээлд байлгах зорилгоор нөгөө этгээдийнхээ бэлгийн халдашгүй байдал, бэлгийн эрх чөлөөг зөрчсөн, хүүхдээ бэлгийн харилцаанд оруулахаар завдсан, оруулсан, бэлгийн шинжтэй бусад үйлдэлд уруу татсан, шаардсан зэрэг үйлдлийг ойлгоно.

4 Эдийн засгийн хэлбэр

гэдгийг гэдгийг гэр бүлийн гишүүн, нөгөө гишүүдийг өөрийн эрхшээлд байлгах зорилгоор нөгөө этгээдийнхээ хөдлөх ба үл хөдлөх, түүнчлэн мөнгөн хөрөнгө, цалин хөлсийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг хууль бусаар хязгаарласныг ойлгоно.

Гэр бүлийн хүчирхийлэлээс сэргийлэх арга хэмжээнүүд:

1 Утас болон онлайнаар сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг эрчимжүүлэх.

2 Олон нийтийн мэдээллийн эх үүсвэр ашиглан өрх гэр бүлийн халуун дулаан уур амьсгал, харилцааг дэмжих, стресс бууруулах арга замуудыг сурталчлах, эерэг хандлага нэмэгдүүлэх ажлыг нэмэгдүүлэх.

3 Эрэгтэйчүүдийн зан үйл, амьдралын зөв хэв маягийг таниулах, сурталчлах, зан үйлд нөлөөлөх сургалт зохион байгуулах.


4 Ахуйн хүрээний архидалт (ГБХ-ийн гэмт хэргийн 91.8%, зөрчлийн 94.2% нь гэр, орон сууцад гарсан)-ыг бууруулахад согтууруулах ундаа борлуулах цэг, цагийн хуваарьт хязгаарлалт хийх, үнийг татвараар зохицуулах.

5 Өрх, гэр бүлийн эдийн засгийн дарамтыг багасгах арга хэмжээг эрчимжүүлэх.

Таны хөршид гэмт хэрэг хүчирхийлэл үйлдэгдсэнийг мэдвэл хэнд хандах вэ?


Цагдаагийн байгууллагын 102 болон хүчирхийллийн мэдээлэл үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн болон хууль зүйн зөвлөгөө өгдөг 107, хүүхдийн тусламжийн 108 тусгай дугаарын утсанд хандаарай. Эдгээр дугаарууд нь үнэ төлбөргүй бөгөөд 24 цагийн турш ажилладаг байна. Түүнчлэн Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн 96490505 утсаар нөхцөл байдлын мэдээллээ өгч, зөвлөгөө авах боломжтой юм.

Хүчирхийлэлд өртсөн иргэд хамгийн түрүүнд хаана хандаж болох вэ?



К Оршуулгын үйлчилгээ

Оршуулгын үйл ажиллагаа гүйцэтгэх дараалал



УЛААНБААТАР ХОТЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ОРШУУЛГЫН ГАЗРУУД



Нас барсны хасалт хийлгэх, оршуулгын тэтгэмж авах

Иргэний нас барсны бүртгэлийг Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд зааснаар доорх баримт бичгийн аль тохирохыг бүрдүүлж аймаг, нийслэлд **3 хоног**, сум, дипломат төлөөлөгчийн газарт **7 хоногийн** дотор бүртгүүлнэ.

Нас барсны хасалт хийлгэхэд бүрдүүлэх материал:

- 1 Талийгаачийн иргэний үнэмлэх /Насанд хүрээгүй бол төрсний гэрчилгээ, эцэг эхийн иргэний үнэмлэх, эцэг эхийн гэрлэлтийн баталгаа, бичиг баримтгүй хүн бол оршин сууж байсан хорооны тодорхойлолт, оршин суух хаяг байхгүй тохиолдолд архивын лавлагаа/
- 2 Нас барсан тухай эмнэлгийн магадалгаа “АМ-07 маягт” /Өвчний улмаас гэртээ нас барсан тохиолдолд өрхийн эмнэлгийн тодорхойлолт авч харьяа дүүргийн эмнэлгээс “АМ-07 маягт” авна. Зуурдаар нас барсан тохиолдолд Шүүх эмнэлгийн “АМ-07 маягт”/
- 3 Хасалт хийлгэхээр материал бүрдүүлсэн хүн өөрийн бичиг баримттай ирэх

Оршуулгын тэтгэмж авах эрх

- 1 Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг 36 сараас доошгүй хугацаагаар төлсөн даатгуулагч нь ердийн өвчин, ахуйн ослын улмаас нас барвал түүний оршуулганд зориулан оршуулгын тэтгэмж олгоно.
- 2 Даатгуулагч нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас нас барсан бол оршуулгын тэтгэмжийг шимтгэл төлсөн хугацааг харгалзахгүйгээр олгоно.
- 3 Нийгмийн даатгалын хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж авч байсан иргэн нас барвал түүний оршуулганд зориулан оршуулгын тэтгэмж олгоно.

Оршуулгын тэтгэмж авах иргэн нь даатгуулагчийг нас барснаас хойш 28 хоногийн дотор багтаан хүсэлт гаргах эрхтэй.

Оршуулгын тэтгэмж авахад бүрдүүлэх материал:

1. Нас барсны гэрчилгээ
2. Талийгаачийн иргэний үнэмлэх
3. Нийгмийн даатгалын дэвтэр /Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг төлснийг гэрчлэх хөдөлмөрийн дэвтэр буюу архивын лавлагаа/
4. Тэтгэврийн дэвтэр
5. Тэтгэмж хүлээн авах хүний иргэний үнэмлэх

Хэрвээ үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас нас барсан бол Үйлдвэрлэлийн ослын акт

Бичиг баримт бүрдүүлэх

Иргэн гэртээ өвчний улмаас нас барсан тохиолдолд эмнэлгийн гэрчилгээ /маягт: ам7/ хэрхэн авах

- 1 Түргэний эмчийн өгсөн бичгийг өрхийн эмнэлэгт авч очих
- 2 Түргэний эмчийн бичгийг өрхийн эмчийн тодорхойлолт болгож авах
- 3 Өрхийн эмчийн өгсөн тодорхойлолтыг харьяа дүүргийн “эрүүл мэндийн төв” буюу амбулатори дээр авч очих
- 4 Нас барсан тухай эмнэлгийн /маягт: ам-7/ авна

Иргэн эмнэлгийн бус нөхцөлд болон гаднын нөлөөтэй нас барсан тохиолдолд эмнэлгийн гэрчилгээ /маягт: ам7/ хэрхэн авах

- 1 Түргэний эмчийн өгсөн бичгийг шүүх эмнэлэгт авч очих
- 2 Шүүх эмнэлгээс “нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ” /маягт: ам-7/ авна

БУЯНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЛАВЛАХ
7016-2222

Цахимаар авах боломжтой төрийн байгууллагуудын үйлчилгээ

Иргэдийн цаг, хугацааг хэмнэх, иргэдэд төрийн үйлчилгээ чөлөөтэй хүрэх, хүнд суртлыг арилгахад төрийн үйлчилгээ цахим байх зайлшгүй шаардлага тулгарсан. Таны санал гомдол, өргөдлийг түргэн шуурхай авах төрийн үйлчилгээнүүдийг доор дурдлаа.

Цахимаар авах боломжтой төрийн байгууллагуудын үйлчилгээ

№	Байгууллага	Үйлчилгээний нэрс
	www.e-mongolia.mn цахим системээр үзүүлэх үйлчилгээ	
1	Улсын бүртгэлийн ерөнхий газар	Төрсний бүртгэлийн лавлагаа
		Гэрлэсний бүртгэлийн лавлагаа
		Гэрлэлт бүртгэлгүй тухай лавлагаа
		Гэрлэлт дуусгавар болсны бүртгэлийн лавлагаа
		Регистрийн дугаарын тухай лавлагаа
		Регистрийн дугаар сольж, шинээр олгосон тухай лавлагаа
		Овог, эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэлийн лавлагаа
		Үндэсний энгийн гадаад паспортын бүртгэлгүй тухай лавлагаа
		Үндэсний энгийн гадаад паспорт анх удаа авсан тухай лавлагаа
		Үндэсний энгийн гадаад паспорт дахин авсан тухай лавлагаа
		Иргэний үнэмлэхийн лавлагаа
		Оршин суугаа хаягийн лавлагаа
		Цахим бүртгэлд хамрагдсан эсэх лавлагаа
		Хуулийн этгээдийн бүртгэлгүй тухай лавлагаа
		Хуулийн этгээдийн хаягийн лавлагаа
		Хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа
		Хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн тухай лавлагаа
		Хуулийн этгээдийн нэр өөрчлөгдсөн тухай лавлагаа
		Хуулийн этгээд татан буусан эсэх лавлагаа
		Хуулийн этгээд улсын бүртгэлд бүртгэлтэй эсэх лавлагаа
		Үл хөдлөх эд хөрөнгөтэй эсэх лавлагаа (тийм үгүй)
		Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа
		Үл хөдлөх хөрөнгийн жагсаалтын лавлагаа
2	Авто тээврийн үндэсний ТӨҮГ	Авто тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн лавлагаа Оношилгоо, техникийн хяналтын үзлэгийн мэдээлэл харах
3	Татварын ерөнхий газар	Татварын өрийн үлдэгдлийн тухай лавлагаа
		Байгууллагын татварын тооцоотой эсэх тухай тодорхойлолт
		Татварын тайлангаа тушаасан эсэх тухай лавлагаа
		Тендерийн тодорхойлолт
		Иргэний тодорхойлолт
4	Цагдаагийн ерөнхий газар	Жолооны үнэмлэхийн лавлагаа
		Галт зэвсэг эзэмших, өмчлөх эрхийн лавлагаа
		Жолоодох эрхийн оноо шалгах
		Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тодорхойлолт
		Хуулийн этгээд эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тодорхойлолт
		Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт
		Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт

№	Байгууллага	Үйлчилгээний нэрс
5	Нийгмийн даатгалын ерөнхий газар	Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт
		Иргэнд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай тодорхойлолт
		Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт
		Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны лавлагаа
6	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар	Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн тодорхойлолт
		Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх шаардлагатай өрхийн тодорхойлолт (Нийслэл)
		Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх шаардлагатай өрхийн тодорхойлолт (Орон нутаг)
		Хүүхдийн мөнгө тэтгэмж олгох тодорхойлолт олгох
7	Боловсрол, соёл шинжлэх ухаан спортын яам	Бүрэн дунд боловсролын гэрчилгээний лавлагаа
		Дээд боловсролын гэрчилгээний лавлагаа
8	Нийслэлийн замын хөдөлгөөний удирдлагын төв	Торгуулийн мэдээлэл харах
		My.dulaan.mn /70047005/ цахим системээр үзүүлэх үйлчилгээ
9	“Улаанбаатар Дулааны сүлжээ” ТӨХК	Төвлөрсөн дулаан хангамжийн системд холбох техникийн нөхцөл олгох
		Төвлөрсөн дулаан хангамжийн системд холбох
		Дулааны эрчим хүчийг тооцох, хэмжих хэрэгсэлийг суурилуулах техникийн нөхцөл олгох
		New.tog.mn /70047004, 341892/ цахим системээр үзүүлэх үйлчилгээ
10	Улаанбаатар Цахилгаан Түгээх Сүлжээ ТӨХК	Цахилгаан хангамжийн техникийн нөхцөл олгох
		Цахилгаан хангамжийн техникийн нөхцөл сунгах
		Цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийн нэр шилжүүлэх
		Цахилгаан хангамжийн техникийн нөхцөл нөхөн авах
		Цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийн зориулалт өөрчлөх
		Цахилгаан дамжуулах агаарын шугам болон кабелийн шугам, дэд станц зөөж байршил өөрчлөх
		www.eservice.ulaanbaatar.mn цахим системээр үзүүлэх үйлчилгээ
11	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба	Спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай өвшөөрөл шинээр олгох
		Спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл сунгах
		Спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгох, нэр шилжүүлэх
		Спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг сунгах
		Спиртийн сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгох, нэр шилжүүлэх
		Улирлын түр үйлчилгээнд спиртийн сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох
		Спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийн эрх сэргээх
		Согтууруулах ундаа худалдах болон түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн хаягийн өөрчлөлт хийх
		Спиртийн сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг сунгах
		Спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийн эрх сэргээх

Цахимаар авах боломжтой төрийн байгууллагуудын үйлчилгээ

	Байгууллага	Үйлчилгээний нэрс
11	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба	Спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай өвшөөрөл шинээр олгох
		Спиртийн сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл шинээр олгох, нэр шилжүүлэх
		Согтууруулах ундаа худалдах болон түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн захирлын нэр солих
		Спиртийн сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийн эрх сэргээх
		Согтууруулах ундаа худалдах болон түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн хаясан үрэгдүүлсэн гэрчилгээ дахин олгох
		Спиртийн сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийн эрх сэргээх
12	Нийслэлийн Архивын газар	Ажилласан жилийг тодорхойлох лавлагаа олгох
		Төрийн архивт баримт хадгалагдаагүй тодорхойлт
		Орон сууц эзэмших эрхийн бичгийн лавлагаа олгох
		Тогтоол захирамжийн лавлагаа олгох
		Цалингийн лавлагаа олгох
		Иргэн, хуулийн этгээдийн захиалгаар мэдээлэл бэлтгэх
		Орон сууцны зориулалт өөрчилсөнтэй холбогдох лавлагаа
		Архитектур төлөвлөлтийн даалгаврын лавлагаа олгох
		Нотариатын лавлагаа олгох
		Акт дүгнэлтийн лавлагаа олгох
		Орон нутгаас шилжиж ирсэнтэй холбогдох лавлагаа
		Цагаатгалын лавлагаа олгох
		Шүүхийн шийдвэрийн лавлагаа олгох
		Өмч хувьчлалтай холбогдох лавлагаа
		Хурлын тэмдэглэлийн лавлагаа олгох
		Нас барагсадын бүртгэлийн лавлагаа
		Уншлагын танхимын үйлчилгээ
		Ерөнхий боловсролын сургууль төгссөнтэй холбогдох лавлагаа
13	Нийслэлийн Байгаль орчны газар	Худалдан авах ажиллагааны холбогдох баримтын лавлагаа
		Банк санхүүгийн холбогдох баримтын лавлагаа



Чухал шаардлагатай утасны жагсаалт

Танд төрийн үйлчилгээг ойртуулахын тулд чухал шаардлагатай утасны жагсаалтыг танилцуулж байна.

Тэмдэглэл

